

The Economist-ийн “Дэлхий 2017” сэтгүүлийн Монгол дахь тусгай зөвшөөрөл эзэмшигч

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY




MobiCom

2016 оны 11 сар №19 (121)

mongolianeconomy.mn

Хөгжлийн 20 жил





ХӨГЖЛИЙН 20 ЖИЛ

ДЭЛХИЙН ХӨТӨЧ
Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл
The Economist-ийн албан ёсны онцгой эрхтэйгээр The World In
сэтгүүлийг монгол хэлээр хоёр дахь жилдээ гаргах гэж байна.

Утас: 7011 5476, 8800 6228
9409 2904, 8608 0000



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэжбаяр (9999 4248)

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:**
И.Отгонжаргал (8800 6228)

РЕДАКТОР:
С.Отгонцэцэг (9927 8928)

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:
Б.Үүрийнтуяа

Б.Энхцэцэг

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

А.Сэвжид

Г.Даваадорж

М.Билгүүн

ОРЧУУЛАГЧ:
Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь


МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариянжав (9409 2904)
Б.Дөлгөөнтамир (8608 0000)

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
I хороо, Экспресс таур. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn
И-мэйл: info@mongolianeconomy.mn
Утас: 976-7011 5476

15160 Улаанбаатар,
Төв шүүдан, ш/ х-2762

Борлуулах цэгүүд:
“Интер ном”
“Номин” супермаркетин бүх салбар
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Good Price”-ийн салбарууд:
Сөүлийн гудамж
Зайсан
Их Монгол

 [facebook.com/
Mongolian.Economy](https://facebook.com/Mongolian.Economy)

 [twitter.com/
EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)

 [youtube.com/user/
MongolianEconomy](https://youtube.com/user/MongolianEconomy)

Эдийн засаг

6 Эринийг эхлүүлэгч

20 жил... Өмнөх зууны төгсгөлд оюутан ахуй насаа үдсэн хүмүүс “Саяхан даа” л гэж хэлнэ.

8 Дэвид Холлидэй:

Мобиком нийгэмд эерэг өөрчлөлт авчрах үүдийг нээсэн

Мобиком цаг хугацаа, орон зайг үл хамааран хүмүүсийг холбож чадсан

9 Үл мэдэгдэх нисдэг биетийн төсөөлөл

Ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг банк үүрэх үү эсвэл зээлдэгч үү.

12 Түүхэн товчоон

15 Хүүхэд төвтэй нийгмийн хариуцлага

Монгол орны хамгийн эрсдэлтэй нөхцөлд байгаа зүйл юу вэ? Төгрөгийн ханш уу, үүл уурхайн салбар уу, эсвэл эдийн засаг үү? Эдгээрийн аль нь ч биш.

17 Тоон мэдээ

18 Хэрэглэгчдийг холбох гүүр

Монголын үүрэн холбооны салбарын анхдагч Мобиком корпорацийн хувьд дээрх бичигдээгүй хуулийг хар дээр цагаанаар бичсэн хууль мэт чухалчилдаг аж.

19 “Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

21 Моод Монголоор дуусдаггүй

Ирээдүйг иргэд, үйлчлүүлэгчдэдээ ойртуулж байдгийн жишээ болгон “Candy” хөтөлбөр болоод Mobiplay үйлчилгээнүүдийг онцолж байна.

24 Хоног сунгалтыг март

Мобиком саяхнаас хоног сунгалтыг халж, тухайн хэрэглэгч нэгжтэй л бол дуудлага хийх боломжийг нээжээ.

24 Задарсан спортын задгай удирдлага

Эхлээд Бээжин, дараа нь Лондонгийн олимпод гарамгай өрсөлдсөн багаасаа бид тийм хэмжээний амжилтыг хүлээсэн нь мэдээж, Риод.

27 Мобикомын

бүтээсэн ертөнц

“Монголд анх удаа” гэх реклам бүрт ашиглах дуртай холбоо үгийн үүсэл Мобикомоос үүдэлтэй гэвэл үнэнээс хол зөрөхгүй.

29 2020 онд гар утас ямар болох вэ?

Японы үүрэн телефоны гол операторын нэг KDDI компанийн дэргэдэх “au” судалгааны төвөөс гар утас хэрэглэгчдийн дунд судалгаа явуулжээ.

30 Сонирхолтой аппликэйшнүүд

Ухаалаг утас таны төсөөлж байгаагаас ч олон зүйл бүтээж чадна. Доорх аппликэйшнүүдийг суулгаснаар амьдрал илүү хялбар бас сонирхолтой болно гэдэгт итгэлтэй байна.




Эринийг эхлүүлэгч

Өнгөрсөн хугацаанд Мобиком корпораци улсын төсөвт 518 тэрбум төгрөгийн татварын орлого хуримтлуулжээ, хуудас 6



Дэвид Холлидэй: Мобиком нийгэмд эерэг өөрчлөлт авчрах үүдийг нээсэн

Англид “Далайн түрлэг бүх хөлөг онгоцыг түрдэг” гэсэн хэллэг байдаг бөгөөд энэ нь нийт эдийн засаг сайжирвал эдийн засгийн бүхий л оролцогчдод ашигтай гэсэн утгатай юм, хуудас 8



Хэрэглэгчдийг холбох гүүр

Хөдөө орон нутагт байрлах 10 мянга орчим диллэрээрээ дамжуулан хэрэглэгчдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байна, хуудас 18



Мобикомын бүтээсэн ертөнц

Монголд үүрэн телефоны үйлчилгээ 1996 онд нэвтрэхэд бид Мобикомтой анх танилцсан, хуудас 27

**Англичуудтай хамтарч
Мазаалайг хамгаална**



Монголын харилцаа холбооны тэргүүлэгч оператор Мобиком корпораци нь Мазаалай баавгайг хамгаалах, өсгөж үржүүлэх, цаашид монгол орны нэн ховор, устах аюулд өртөөд буй ан амьтдыг хамгаалах ажлын хүрээнд Лондоны амьтан судлалын хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зуржээ.

Мобиком 2015 оноос эхлэн дэлхийд нэн ховор, Монголын говь цөлд амьдардаг баавгайн цор ганц зүйл болох Мазаалайг хамгаалах төсөл хөтөлбөрийг БОАЖЯ, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Говийн их дархан цаазат газартай хамтран хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү төслийн эхний жил Мазаалай баавгайн амьдрах орчин болон судалгаа шинжилгээний орчин нөхцөлийг сайжруулах, үнэн бодит мэдээлэл олон нийтэд хүргэх зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлөх технологи ашиглан зургаан сумын нутагт 4-5 цагийн турш хур тунадас оруулсан нь Мазаалайн идэш тэжээл байгалийн нөхцөлд сайн ургах орчин бүрдүүлж чаджээ.

Түүнчлэн судалгаа, шинжилгээ болон олон нийтэд бодит мэдээлэл хүргэх зорилгоор 16 ширхэг хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулсны үр дүнд 35 орчим мазаалайг тоолон бүртгэлжүүлжээ. Өнгөрсөн зун гурван шинэ төл буюу алманцаг /Мазаалайн үр төл/ бүртгэгдсэн нь энэхүү ховор амьтан өсөн үржиж буйг нотолж байгаа юм. Мөн байгалийн хур тунадас, уулын үер, цасны усыг зориудаар хиймэл орчин бүрдүүлэн тунгааж тогтоон барих үндсэн зорилготой хөв байгуулсан байна.

Харин Лондоны амьтан судлалын хүрээлэнтэй хийж буй хамтын ажиллагааныхаа эхлэл болгож ирэх хавар хамгийн сүүлийн үеийн хөдөлгөөн мэдрэгч бүхий камерыг Их говийн дархан цаазат газар нэмж байрлуулахаар төлөвлөөд байна.

Теди төв үйлчилгээний шинэ дэвшил нэвтрүүлээ

Мобиком корпорацийн нэг цэгийн үйлчилгээний төв болох Теди нь хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн олон улсын стандарт, жишигт хүрсэн “ONE STOP SHOP” төсөл хэрэгжүүлээ. Тодруулбал, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэгч өөртөө үйлчлэх боломжтой “S POS” төхөөрөмж ашиглан үүрэн холбооны үйлчилгээ авах боломжтой боллоо.



Хэрэглэгч төлбөрийн картаа ашиглан АТМ-ээр үйлчлүүлэгчтэй адил хэрэглэгч “Теди” төвөөр дамжуулан дараалал, дугаарлалт хүлээлгүйгээр нэгж цэнэглэх, төлбөр төлөх, Candy оноогоороо Мобикомын үйлчилгээ, шинэ дугаар авах болон сэргээх зэрэг үйлчилгээг ч авч болох юм.

Төлбөрөө төлөхөд интернэт шаардлагагүй

Мобикомоор үйлчлүүлэхийн тулд хэрэглэгч үйлчилгээний зааланд биеэр ирэх болон интернэт орчинд смарт утастай байх шаардлагагүй боллоо. Учир нь Мобиком корпораци, Голомт банктэй хамтран гар утсаараа бүхнийг амжуулах Мобайл банк 2.0-ийг нэвтрүүлэн илүү хялбар үйлчилгээг санал болгож байна.

Тодруулбал, та гар утсаараа *1646# руу залган Мобикомын сүлжээ орсон бүх газраас Мобиком болон банкны олон төрлийн үйлчилгээ авах боломжтой гэсэн үг. Хэрэглэгч танд хамгийн хялбар аргаар, цаг зав, зардлаа хэмнэн санхүүгийн төлбөр тооцооны бүхий л асуудлаа Мобайл банк 2.0-оор зохицуулахыг зөвлөж байна. Энэхүү үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг 2222 лавлах утас, Мобайл банк үйлчилгээний бүртгэл болон Голомт банкны 1800-1646 лавлах утсанд хандан авч болно.

ГОЛОМТ БАНК МСБАЙЛ БАНК 2.0

ГОЛОМТ БАНКНЫ ДАНСНААСАА

- Ярианы төлбөр төлөх
- Нэгж цэнэглэх
- Дата багц авах

БОЛОМЖТОЙ БОЛЛОО

МОБАЙЛ БАНК 2.0 ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРЛЭЭ
Мобикомын үйлчилгээг хамгийн ойроос

Илүү хялбар

Мобикомын хэрэглэгчид Монголын аль ч цэгээс гал командын 101, цагдаагийн 102, эмнэлгийн түргэн тусламжийн 103, онцгой байдлын 105 гэсэн дугаарууд руу угтвар кодгүйгээр залгахад тухайн орон нутгийн яаралтай түргэн тусламжийн шугамтай шууд холбогддог болов.

Өөрөөр хэлбэл, хэрэглэгч та Төв аймгийн нутаг дэвсгэрт байхдаа эрүүл мэндийн тусламж хүсвэл 103 дугаар руу өмнө нь ямар ч угтвар кодгүйгээр шууд залгахад хангалттай. Ингэснээр газар зүйн байршлын дагуу тухайн орон нутгийн эмнэлгийн түргэн тусламжийн шугамд шууд холбоно. Үүнтэй адил Гал команд, Цагдаа, Онцгой байдлын яаралтай тусламжийн тусгай шугамд шууд холбогдох боломжийг Мобиком хэрэглэгчиддээ олголоо. ■



Мобикомоос өмнөх харилцаа холбоог төсөөлөхгүй цаг үе иржээ

Хөгжил

ЭРИНИЙГ ЭХЛҮҮЛЭГЧ

Ц.БУНИА

Бизнест анхдагч байна гэдэг хэн бүхний зориглох зүйл биш. Анхдагчид бүх эрсдэлийг үүрч, хамгийн түрүүнд сорилтуудтай нүүр тулдаг. Эсрэгээрээ асуудал, шийдэл нь тодорхойлогдсоны дараа тэдний зассан замыг дагах нь үргэлж эрсдэлгүй, амар хялбар байдаг. Харин анхдагчид үргэлж шинэ санаа, шинэ бүтээгдэхүүнүүд гаргаж, хөгжил дэвшлийг бий болгож байдаг учир тэдний гавьяаг хэн ч булаах боломжгүй.

20 жил... Өмнөх зууны төгсгөлд оюутан ахуй насаа үдсэн хүмүүс “Саяхан даа” л гэж хэлнэ. Аймгийн төвд бол гэртээ суурин утастай айл төдий л олон биш. Сумын төвд бол “холбоо” л холыг ойртуулж, хоёрыг учруулна. Улаанбаатарын

“Төв шуудан”-д хүмүүс утсаар ярих ээлжээ хүлээнэ, хаалган дээр нь дугаарласан жижиг бүхээг дотроос хэн нэгэн нь “Байна уу, ээж үү?” хэмээх нь сонстоно. Ийн ярилцахын тулд тэд магад долоо хоногийн өмнө шуудангаар захидал илгээн өдөр товлосон биз ээ. Өнөөдөр энэ дүр зургийг мэдэхгүй, төсөөлөхгүй үеийнхэн олон болж.

Тэгвэл Монголын уран сайхны “Өнөр бүл” киног үе үеийн үзэгчид сайн мэднэ. Гармаа сонины газраас залруулга бичиж өгсөн тэр нэг тамгатай нарийхан цаасыг Цэрмаад хүргэх гэж ямар их адал явдал туулдаг билээ дээ. 1980-аад оны дүр зураг. Мобикомоос өмнөх харилцаа холбоо ийм л байсан.

Тэр үеэс өнөөг хүртэл Мобиком

олон шинэ үйлчилгээний анхдагч байж ирлээ. Үүрэн холбооны хоёр дахь эрин (2G) гар утаснаасаа мессэж илгээх, гурав дахь үе (3G) дата үйлчилгээ, гар утсаараа дүрсээ харж ярилцах боломжийг олгож, 4G LTE үйлчилгээг iPhone гар утсанд албан ёсны зөвшөөрөлтэйгээр анхлан Мобиком зах зээлд нэвтрүүлсэн билээ. Зөвхөн үүнд үндэслэж тус компанийг Монгол Улсад XXI зууны хөгжлийг түүчээлэгч хэмээн нэрийдэхэд ононо уу гэхээс алдахгүй. Үүрэн холбооны үйлчилгээ бий болсноор монголчууд шинэ хурд эзэмшсэн. Зөвхөн мэдээлэл дамжуулах тухай биш, хүмүүс секунд ч хоцролгүй мэдээлэл авдаг болсноор цагаа олж зөв шийдвэр гаргаж чадах болсон юм.

Хоёр жилийн өмнө тэд үндэсний ▶

▶ гэж хэлж болох цахим мөнгийг хамгийн анх хэрэглээнд нэвтрүүлээд байна. Хэрэглээнээсээ хуримтлуулдаг “Candy” (чихэр) бол Санхүүгийн зохицуулах хорооноос баталгаажсан цор ганц цахим мөнгө юм. Үүгээрээ хэрэглээг урамшуулдаг бусад лоялти үйлчилгээнээс ялгарч чадна. Нэг “чихэр” нэг төгрөгтэй тэнцүү. 20 Candy-гээр та худгаас 20 литр ус авч болно. Эсвэл гэрийнхээ цахилгааны төлбөрийг хийчихнэ. Цаашлаад Мобикомоос нэгж, “Coffee bean”-ээс кофе, “Монос”-оос эм гэх мэтчилэн цахим мөнгөөр тооцоо хийдэг үйлчилгээний газрууд, орон нутаг дахь гэрээт борлуулагчидтай төлбөр тооцоо хийх боломжтой болж монголчууд цахим мөнгөний эринд хөл тавиад байна.

Өнгөрсөн хугацаанд Мобиком корпораци улсын төсөвт 626 тэрбум төгрөгийн татварын орлого хуримтлуулж, улсад төлсөн татварынхаа хэмжээгээр тогтмол ТОП 10-д багтаж иржээ. Монгол Улсын харилцаа холбооны салбар, технологийн дэвшилд хийсэн тэдний хөрөнгө оруулалт нь их наядаар хэмжигдэж байна. Үндсэндээ компанийн ашиг эргээд хөрөнгө оруулалтын зардал болдог хэмээн тус корпорацийн Зах зээл, бизнес хариуцсан дэд захирал М.Энхсайхан хэлсэн юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай компани учраас хамаг орлогоо гадагш урсгадаг гэх хардалт олны дунд бий. Гэвч үнэн хэрэгтээ гадаадын хөрөнгө оруулалтыг Монголын зах зээлд татаж авчирснаар өнөөгийн амжилтад хүрч, энэ баялгийг бүтээсэн билээ. “Хэрэв ганцаараа хийвэл 100 төгрөг олох ажлыг хамтарч хийснээр орлогоо 150 төгрөг болгож байвал гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Эсрэгээрээ 100-гаас доош төгрөг болон буурч байгаа бол шаардлагагүй байжээ гэж ойлгож болно” хэмээн М.Энхсайхан захирал тайлбарласан юм. Тэгэхээр Мобикомын хувьд энэхүү хөрөнгө оруулалт Монголын ард түмэнд ашгаа өгсөн болох нь харагдаж байна.

Өнөөдөр тус корпораци нийт 1500 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна. Энэ нь магад 1500 айлын орлогын шууд эх үүсвэр болдог гэсэн үг. Корпорацийн хувьд ч ажилтнуудынхаа гэр бүлийг дэмжиж, тэдний нийгмийн

асуудлыг шийдвэрлэхэд анхаардаг нь байгууллагын тэргүүн зарчим ажээ. Тухайлбал, шинээр гэр бүл болсон ажилтнуудад 25.5 сая, шинэ хүүхэдтэй болсон ажилтнуудад 46.8 сая, алдарт эхийн I, II одонтой ээжүүдэд 20.2 сая төгрөг олгожээ. Мөн ажилтнуудын жил бүрийн эмнэлгийн үзлэг болон эрүүл мэнд, ослын даатгалд 270 гаруй сая төгрөг зарцуулсан байна.


Түүнчлэн дотоодын боловсролын байгууллагуудтай хамтран хагас жил тутамд ажилтнуудаа сургалтад хамруулж, нарийн мэргэжилтэн, тухайлбал, инженерүүдээ гадаадад тэтгэлэгтэйгээр сургадаг аж.

Харин Мобикомын ажилтнуудын бахархал нь хариуцлагаа ухамсарласан, нэр хүндтэй компанийн нэг эд, эс нь байх явдал. Тэр дундаа “Мобиком бол итгэл хүлээсэн компани” гэдэг нь хамгийн чухал.

“Мобикомыг анхлан шинэ технологи нэвтрүүлнэ” гэхэд эргэлзэх хүн ховор. Хэдийгээр тариф нь үнэтэй гэж зарим нь шүүмжилдэг ч үүний ард компаниас шалтгаалахгүй олон

асуудал байдгийг тэр бүр мэдэхгүй бөгөөд Мобиком 20 жилийн турш зах зээл дээр тэргүүлэгчийн байр сууриа хадгалсаар л байна. Өнөөдөр Монгол Улсын хүн амын тал нь тус компанийн үйлчлүүлэгч. Хэрэглэгчдийнхээ тоогоор нийт зах зээлийн 40-өөс илүү хувийг эзэлдэг “Давамгайллагч” гэх статустай. Давамгайллагч тарифаа хэт бууруулбал өрсөлдөгчдөө зах зээлээс шахан гаргаж, монополь болон үлдэнэ. Тиймээс Мобикомын үнэ тарифын асуудлыг төрөөс тусгайлан хууль журмаар зохицуулж байдаг аж. Үнэ бол өрсөлдөх чадварын чухал хүчин зүйл. Ийм нөхцөлд ч тэд хэрэглэгчдийнхээ нэгдүгээр сонголт байсаар буйг итгэл даадаг чанар, шинэлэг үйлчилгээтэй нь холбон тайлбарлахаас өөр аргагүй юм.

Ийнхүү Мобиком анх байгуулагдсан нь Монгол Улсад хөгжлийн нэгэн шинэ эрин үеийн эхлэл болсон шигээ компанийн хөрөнгө оруулалт бүр нь дэлхийн хөгжил дэвшилтэй монголчуудыг мөр зэрэгцэн алхуулах гэсэн агуу зорилго байсаар иржээ. ■



CEO

Дэвид Холлидэй: Мобиком нийгэмд эерэг өөрчлөлт авчрах үүдийг нээсэн

И.ОТГОНЖАРГАЛ

Мобиком корпорацийн гүйцэтгэх захирал Дэвид Холлидэйтэй ярилцлаа.

Юуны өмнө танд сэтгүүлийнхээ уншигчдын өмнөөс 20 жилийн ойн баярын мэнд дэвшүүлье! Та Мобиком корпорацийн Монгол Улсын хөгжилд оруулсан хувь нэмрийг хэрхэн харж, үнэлж байна вэ?

-Маш их баярлалаа, танай сэтгүүлийн нийт захиалагч болон уншигчдад Мобиком корпорацийн

Өөрөөр хэлбэл, манай 3G, 4G дата болон бусад илүү өндөр дэвшилтэт технологийн ачаар бүхий л нийгмийн харилцааг ойртуулсан гэсэн үг.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын судалгаагаар интернэт хэрэглэгчийн тоо 10 хувиар нэмэгдэхэд улсын ДНБ 1.4 хувиар өсдөг гэсэн байдаг. Энэ нь аль ч улсын эдийн засгийн өсөлтөд харилцаа холбооны технологи хэрхэн нөлөөлдгийг мэдэгдэхүйцээр харуулж байна. Энэ өөрчлөлтийг Монгол Улсын иргэдэд авчрахын тулд өнгөрсөн он жилүүдэд хийсэн хөрөнгө оруулалт маш чухал ач холбогдолтой байсан. Жишээ нь, Мобиком үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш 600 тэрбум гаруй төгрөгийг Монгол Улсын төсөвт аж ахуйн нэгжийн албан татвар болон бусад татвар, хураамжийн хэлбэрээр төлжээ. Мобикомын мянга мянган ажилтан, орон даяар үйл ажиллагаа явуулж буй 12 мянга гаруй дилерийн олон жилийн турш төлсөн татварыг тооцвол маргаангүй олон тэрбум төгрөгөөс давна.

Бид ойролцоогоор 1.25 их наяд төгрөгийг Монгол Улсын дэд бүтцийн хөгжилд шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулсан.

10 мянгаас илүү шинэ ажлын байр бий болгож, Монголын мянга мянган том, жижиг ханган нийлүүлэгч компанитай хамтран ажиллаж, тэдэнд орлого оруулж, өрсөлдөх чадавхыг нь нэмэгдүүлэн, бидэнтэй хамт өсөн дэвжих боломж олгохын тулд олон тэрбум төгрөг зарцуулжээ. Мобиком нь Монголын орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарыг үүсгэн байгуулагч гишүүдийн нэг бөгөөд энэ салбар хүн бүхний цаг, мөнгийг хэмнэж, асар олон шинэ боломж, бололцоо зэрэг хамгийн чухал нөөцийг бүх л бизнест бий болгож байдаг. Англид “Далайн түрлэг бүх хөлөг онгоцыг түрдэг” гэсэн хэллэг байдаг бөгөөд энэ нь нийт эдийн засаг сайжирвал эдийн засгийн бүхий л оролцогчдод ашигтай гэсэн утгатай юм. ▶



Мобиком цаг хугацаа, орон зайг үл хамааран хүмүүсийг холбож чадсан

хамт олны өмнөөс мэнд дэвшүүлье! Тийм ээ, өнгөрсөн 20 жилийн хугацаа маш сонирхолтой бөгөөд маш олон сорилт бүхий он жилүүд байлаа. Үүрэн холбооны салбарын анхдагч компанийн хувьд Мобиком Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, олон төрлийн бизнесийн үйл ажиллагааг тэлэхэд тусалсан гэж бид харж байна. Хамгийн чухал нь бид цаг хугацаа, орон зайг үл хамааран ард иргэдийг холбож чадсан нь Монголын харилцаа холбооны салбар төдийгүй нийгэмд эерэг өөрчлөлт авчрах үүд хаалгыг нээсэн юм. Ингэснээр хүмүүс гэр бүл, найз нөхөдтэйгөө холбогдох эсвэл хэн нэгэн нь өвдсөн тохиолдолд яаралтай түргэн тусламж дуудахын тулд шуудан дээр хэдэн цаг дараалал үүсгэн хүлээх шаардлагагүй болсон билээ.

► Харилцаа холбооны технологийн хөгжлийн ачаар сүүлийн 4-5 жилийн хугацаанд дижитал контент, аппликейшн болон үзвэр үйлчилгээний салбарууд итгэхийн аргагүй хурдацтай өслөө. Дэлхий нийтийн энэ чиг хандлага Монгол Улсад ч ажиглагдаж байна.

-Үүрэн холбоо Монголд хамгийн үсрэнгүй хөгжсөн салбар гэдгийг хэн хүнгүй мэднэ. Монголын жижиг зах зээлд гарсан техник технологийн энэ их хөгжил дэвшлийн гол хөдөлгүүр нь юу байсан гэж Та боддог вэ?

-Таны хэлж байгаа үнэн. Монголд зөвхөн энэ салбар дэлхийн хөгжлийн хурдтай хөл нийлүүлэн алхаж байна гэж хэлж болно. Тухайлбал, үүрэн харилцаа холбооны дэлхийн чиг хандлага болоод байгаа 4G технологийг дэлхийн зарим улсаас түрүүлж Монголд нэвтрүүлээ шүү дээ. Тиймээс бид дэлхийтэй хөл нийлүүлээд зогсохгүй хуучны техник технологиосоо салаагүй байгаа зарим улсуудыг давж гарсан. Учир нь Монгол Улс энэ салбарт сүүлд хөл тавьсан ч 20 жилийн тасралтгүй хөдөлмөр, шинэ технологи байнга нэвтрүүлж ирсний ачаар үсрэнгүй хөгжил бий болгож байгаа нь сайшаалтай.

Анхандаа бид хэрэглэгчдээ Улаанбаатар хот дотор дуут яриа болон мессежээр холбох зорилготой байлаа. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Мобиком ч ахин дэвшсээр өнөөдөр манай хэрэглэгчид орон даяар холбогдлоо. Тэд дэлхийн бусад орны 500 гаруй сүлжээнд нэвтэрч, гадаад оронд явж байхдаа чөлөөтэй ярьж, датагаа ашиглах боломжтой болсон. Мэдээлэл харилцаа холбооны технологийн салбарын хөгжил олон шинэ боломж бий болгосон. Дата, нэмүү өртөг шингэсэн үйлчилгээ болон олон нийтийн сүлжээг ашиглах хэрэгцээ ч энэ хэрээр асар их нэмэгдсэн. Суурин утас, ухаалаг оффисын шийдэл, VSAT хиймэл дагуулын холболт, дотоодын болон олон улсын виртуал хувийн сүлжээ зэрэг мэдээлэл харилцаа холбооны технологийн цогц шийдлийг бизнесүүдэд санал болгосноор тэдэнд нэмүү өртөг бий болгох боломж олгосон. Ер нь манай салбарын боломж, бололцоо хязгааргүй юм.

-Эрүүл өрсөлдөөнтэй бизнес байнга өөдлөн дэвждэгийг Монголын үүрэн холбооны салбарынхан мэдэрч, бусдадаа үлгэрлэж яваа гэж боддог. Ширүүн өрсөлдөөнд танайх, жишээ нь, хамгийн олон хэрэглэгчтэй хэвээр байгаагийн гол нууц юу вэ?

-Үүнийг нэг үгээр тайлбарлаж болно, тэр нь үйлчилгээ. Мобиком Монгол Улсын нийт хүн амын бараг тал хувийг өдөр тутам харилцаа холбооны үйлчилгээгээр хангадаг бөгөөд энэ үүрэг хариуцлагаа бид маш сайн ухамсарладаг. Бидний хувьд бүх үйлчлүүлэгч чухал. 1.3 сая хэрэглэгч сар тутамд манай Үйлчилгээний нэгдсэн төв 2222 шугамд холбогдож, өөрсдийн асуултад хариу авдаг, мөн орон даяар үйл ажиллагаа явуулж

буй салбаруудаас өдөр тутам үйлчилгээ болон туслалцаа авч байна.

Бидний үйлчилгээ төгс түвшинд хүрсэн үү гэвэл хараахан үгүй. Жишээ нь, зарим байгууллагууд газар доорх шилэн кабелийг хайхрамжгүйгээр тастаж, зарим суманд сүлжээ тасрах тохиолдол гардаг. Өнгөрсөн жил шүүхээс нэг компани манайд 40 сая төгрөгийн торгууль төлөх шийдвэр гаргасан. Энэ бол их чухал. Ингэснээр бусад оператор компани үүнтэй адил арга хэмжээ авч, бүгд нэгдэн барилгын үйл ажиллагаа явуулж буй гэрээт компаниудын хандлагыг өөрчилж, илүү мэргэжлийн болгох шаардлагатай. Өнөөдөр харилцаа холбооны сүлжээ ард иргэд болон бизнес эрхлэгчдийн өдөр тутмын ажил хэрэгт амин чухал ач холбогдолтой болсон. Уг сүлжээнд хайхрамжгүйгээр гэмтэл учруулахыг гэвчих ямар ч боломжгүй. Хэрэглэгчид бидний бизнесийн соёл, ёс зүй, шударга, ил тод байдал, үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах үүрэг, мэдээллийн аюулгүй байдал, үйл ажиллагаагаа эрхэлж буй арга барил болон нийгэмд гүйцэтгэж буй үүргийг үнэлж байгаа гэж бодож байна.

Монголын тэргүүлэх компаниудын нэг болохын хувьд Мобиком нь Монгол Улсын хууль, журмыг чандлан мөрдөх талаар байнга үлгэр жишээ үзүүлэх ёстой. Ер нь бид тавьсан шаардлагыг давуулан биелүүлэхийн төлөө үргэлж хичээдэг. Хууль тогтоомж, татвар, ил тод байдал, ёс зүй, хөрөнгө оруулалт, нийгэмд оруулж буй хувь нэмэр зэрэг бүхий л үүрэг хариуцлагыг маш чухалчилж авч үздэг. Бид Монгол Улс дахь нийгмийн хариуцлагын хамгийн хүчтэй хөтөлбөртэй компани бөгөөд энэ нь бусад бизнесийн аж ахуйн нэгжид үлгэр жишээ болно гэж найддаг.

Мобиком корпораци хүүхдүүдэд маш их анхаарал хандуулдаг. Тухайлбал, бид сар бүр нэг сургуульд халуун ус, боловсон суултуур, гэрэлтүүлэг, цэвэршүүлэх технологи бүхий халаалттай, цогц ариун цэврийн байгууламж барьж, суурилуулж өгдөг. Ингэснээр өдөр тутам дор хаяж 35 мянган хүүхдийг ариун цэврийн хангалтгүй нөхцөлөөс болж өвчлөх аюулаас сэргийлж байгаа юм. Мөн хүүхдийн тусламжийн утас 108-ыг санаачлан хэрэгжүүлсэндээ бид ихэд бахархдаг. Засгийн газрын дэмжлэг, олон байгууллагын хүчин чармайлт орсон энэ үйлчилгээ сүүлийн 24 сарын хугацаанд 360 мянган дуудлага хүлээн авч, хүндрэл бэрхшээл тулгарсан хүүхдүүдэд тусалсан. Гэхдээ, харамсалтай нь, эдгээр дуудлагын бараг таван мянга гаруйд нь цагдаа сэргийлэх зэрэг ►

Мэдээллийг хамгаалахын тулд хүчирхэг компанийн засаглалыг бий болгож, мөн хамгийн сүүлийн үеийн олон улсад ашиглаж буй хамгаалалтын хэрэгсэлд хөрөнгө оруулсан.

► байгууллагын оролцоо шаардлагатай болсон. Энэ нь таны асуулттай шууд холбоотой биш байж болох ч Мобикомын хувьд үйлчилгээ гэдэгт бидний нийгэмд оруулах хувь нэмэр багтдаг.

-Аюулгүй байдлын хувьд ямар байна вэ? Хүмүүсийн хэрэглэж буй төхөөрөмж илүү боловсронгуй болж, илүү их мэдээлэл хадгалахын хэрээр хакердуулах аюул эсвэл өгөгдлийн гажуудлын талаар их дуудах болж?

-Мобиком мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалын асуудалд хамгийн их анхаарал хандуулдгийг хэрэглэгчид мэднэ. Мэдээллийг хамгаалахын тулд хүчирхэг компанийн засаглал бий болгож, мөн хамгийн сүүлийн үеийн олон улсад ашиглаж буй хамгаалалтын хэрэгслүүдийг суурилуулахад асар их хөрөнгө оруулалт хийсэн. Үүний талаар илүү тодорхой нарийн мэдээллийг миний бие мэдээж өгч болохгүй. Гэвч бид хэрэглэгчдэдээ мэдээллийн аюулгүй байдлын талаар дэлхийн топ байгууллагуудаас баталгаа авч, түүнийг чанд сахин мөрддөг гэдгийг баттай хэлэх нь зүйтэй. Жишээ нь, ISO 9001 олон улсын

чанарын удирдлагын систем болон ISO 27001 олон улсын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын системээр баталгаажсан. Мобиком олон улсын эдгээр стандартыг авсан Монгол Улс дахь цорын ганц оператор компани.

-Дэд бүтцийг бэхжүүлэх, технологи нэвтрүүлэх гээд маш өндөр зардалтай, хөрөнгө оруулалт их

шаарддаг салбар. 20 жилийн хөгжлийн түүхийг бүтээхэд та бүхний хамгийн их хөрөнгө оруулалт зарцуулсан он жилүүд аль вэ? Эдийн засгийн хүндрэлтэй үед бизнесийн ямар стратеги барьж байгаа вэ?

-Дэд бүтэц нь шууд утгаараа харилцаа холбооны салбарын суурь болж өгдөг. Манай компани жил бүр шинэ сүлжээ дамжуулах станцуудыг зуу зуугаар нь Монгол Улсын өнцөг булан бүрт суурилуулдаг. Дээрээс нь шинэ сүлжээ дамжуулах эдгээр станцыг Улаанбаатар хоттой холбох шаардлагатай байдаг. Мөн одоогийн сүлжээ дамжуулах станцуудын хүчин чадлыг илүү нэмэгдүүлэхийн тулд бид жил бүр шинэчлэлт хийдэг. 2G, 3G, 4G сүлжээ нэвтрүүлэх болон хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангахын тулд илүү их хөрөнгө оруулалт хийж байна гэсэн үг. Бид бараг 7500 км шилэн кабель болон 3000 км гаруй богино долгионы суурь сүлжээтэй байна. Эдгээр нь илүү их мэдээллийн технологи болон системийн хүчин чадал шаарддаг бөгөөд үүнд Мобикомын хөрөнгө оруулалт хамгийн

ихээр зарцуулагддаг, (харилцаа холбооны бусад бүх компани ч мөн адил үүнд хамгийн их хөрөнгө зардаг). Бид саяхан Европ болон Азийг Монгол Улсаар дамжин холбох транзит интернэт сүлжээ суурилуулж, ОХУ-аас БНХАУ хүртэл хамгийн сүүлийн үеийн төхөөрөмж ашиглан, шилэн кабель татсан. Мобикомын дэд бүтцэд зарцуулж буй хөрөнгө оруулалт хэзээ ч зогсохгүй. Бид сүүлийн 24 сарын хугацаанд өнгөрсөн 10 жилд барьж байгуулснаас ч илүү олон сүлжээ дамжуулах станц барьсан. Манай компани өөрсдийн сүлжээндээ итгэл төгс байдаг. Мобикомын LTE сүлжээ Apple-ийн нарийн шаардлагуудыг давж, тус компаниас баталгаажсан Монгол Улс дахь цорын ганц LTE сүлжээ болсноороо маш их бахархаж байгаа. Энэ нь Мобикомын хэрэглэгчид 4G LTE сүлжээнд iPhone болон бусад ухаалаг төхөөрөмжийн бүхий л үйлдлийг ашиглаж болно гэсэн үг.

Бид мөн хэрэглэгчдэдээ байнга анхаарал хандуулж, санаа тавьж байдаг. Энэ оны эхээр хэрэглэгчдэд илүү их боломж бололцоо олгох, үйлчилгээг хялбарчлах үүднээс системээ шинэчилсэн. Ингэснээр “Миний Mobi” нэртэй дараа төлбөрт шинэ багцыг хэрэглэгчдэдээ санал болгох боломжтой болсон. Уг үйлчилгээний гол давуу тал нь хэрэглэгчид зөвхөн өөрийн хүссэн үйлчилгээг, хүссэн хэмжээгээрээ, хүссэн нөхцөлөөрөө сонгох боломж олгож байгаа. Энэ нь операторуудын санал болгодог цөөхөн хэдэн тогтсон багцын оронд хэрэглэгчдэд илүү их сонголт олгож буй юм. Бид хэрэглэгчдээ сонсдог. Тухайлбал, үйлчлүүлэгчдийн хүсэлтийн дагуу урьдчилсан төлбөрт дугаарын үйлчилгээний хүчинтэй хугацааг хязгааргүй болгосон. Ингэснээр хэрэглэгчид маань үйлчилгээний хугацаандаа санаа зовохгүйгээр зөвхөн хэрэглээндээ л анхаарах боломж олгож байгаа юм. Бид 2015 онд хосолсон төлбөрт Hybrid багц нэвтрүүлж, хэрэглэгчдэд дараа төлбөрт үйлчилгээний давуу талуудыг мэдрэхийн зэрэгцээ хэрэглээгээ бүрэн хянах боломж бүрдүүлсэн. Эдгээр нь үйлчлүүлэгчдэд манай хэрэглээг илүү үр ашигтай замаар хүргэх зорилготой шинэлэг бөгөөд Монголын үүрэн холбооны салбарт анх удаа нэвтрүүлж буй үйлчилгээнүүд юм.

-Өрсөлдөгч компаниуд технологийн дэвшлийг нэвтрүүлэх хурдаа бууруулахгүй байна. Мобикомын хувьд зах зээлийг тэргүүлэгчийн байр сууриа хадгалахын тулд цаашид ямар төлөвлөгөөтэй байна вэ?

-Нийт эдийн засаг сайжирвал бүх оролцогчдод ашигтай гэж би түрүүнд хэлсэн. Бид Монголын үүрэн холбооны бизнест анхдагч байхын сацуу Мобиком өнөөгийн үйлчилгээний стандартыг тогтоож өгсөн. Үр дүнд нь бидний тогтоосон стандартыг хүлээн зөвшөөрдөг. Нэг ёсондоо өрсөлдөөн бий болгосон нь сайн зүйл боловч нөгөө талаараа хэрэв манай өрсөлдөгчид биднийг ►

Англид “Далайн түрлэг бүх хөлөг онгоцыг түрдэг” гэсэн хэллэг байдаг бөгөөд энэ нь нийт эдийн засаг сайжирвал эдийн засгийн бүхий л оролцогчдод ашигтай гэсэн утгатай юм.

► ердөө л байнга дуурайн хуулаад байвал тийм ч сайн зүйлд хүргэхгүй. Ингэх нь бүтээлч байдлыг үгүй хийж, үүний улмаас өрсөлдөөн багасч, үр дүнд нь хэрэглэгчдийн сонголтыг багасгахад хүргэдэг. 4G шиг шинэ технологийг зах зээлд нэвтрүүлэх нь операторуудын хооронд өрсөлдөөнийг тодорхой хэмжээгээр нэмж байгаа ч энэ бол ердөө үйлчилгээг хүргэх нэгэн төрлийн хэрэгсэл юм. Жинхэнэ манлайлагчийг тодорхойлогч нь үйлчилгээг хүргэх хэрэгслийг хэрхэн ашиглах вэ гэдэгт оршдог. Би компанийнхаа төлөвлөгөөг олон нийтэд дэлгэж болохгүй ч бидний хүчин чармайлтаа төвлөрүүлэх гол зүйл бол энэ байх учир үүнийг анхааралтай ажаарай л гэж хэлмээр байна.

-Дэлхийн үүрэн холбооны технологийн дэвшил ойрын хугацаанд бүр л нарийсаж, өндөрсөх нь. Тухайлбал, Японы “au” судалгааны төвөөс гаргасан мэдээллээр бол 2020 онд гар утас гэхэд л бараг “амьтай” болж магадгүй нь. Дэлхийн технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхдаг салбарын хувьд Монголын үүрэн холбооныхонд ямар асуудал тулгамдаж байна вэ?

-Монгол Улсад ажиллаж, амьдарч буй хүн бүр хамгийн сүүлийн үеийн үйлчилгээ авч, технологи ашиглах ёстой. Мобиком хамгийн шинэ бөгөөд шилдэг, дэвшилтэт технологийг Монголын хэрэглэгчдэд авчрахыг хичээх болно. Үүнд шаардлагатай хөрөнгө оруулалт бусад компанийн хувьд хамгийн том сорилт болж байна. Харин Мобикомын хувьд ийм нөөц бололцоо байгаа бөгөөд Монгол Улсын иргэдийг бусад улс оронтой хөл нийлүүлж, мөн хэрэв боломжтой бол бусад улс орноос ч өмнө байлгахыг зорих болно.

-Ярилцлагын төгсгөлд та 20 жилийн ойгоо тохиолдуулаад хэрэглэгч, үйлчлүүлэгчид болон үсрэнгүй хөгжил дэвшлийг эх орондоо авчралцсан салбарынхан, корпорацийн хамт олондоо юу гэж хэлэх вэ?

-Үүрэн харилцаа холбоог Монгол Улсад бий болгосон Мобикомын замнал адал явдлаар дүүрэн байлаа. Сүүлийн 20 жилд хуримтлуулсан ололт амжилт болон туршлагыг авч үзвэл Монголын орон даяар хэрэглэгчдээ холбохын тулд ирэх 20

жилд хийх хөрөнгө оруулалт болон шаардлагатай инновацийг Мобиком корпораци үргэлжлүүлэх хамгийн бололцоотой байр сууринд хүрсэн байна. Бид цаашид хамгийн хурдан бөгөөд найдвартай үйлчилгээндээ тулгуурлан бизнесүүдийг нэмүү



өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах шийдэлд анхаарлаа хандуулах болно. Засгийн газар, хэрэглэгчид, бизнес эрхлэгчид болон бусад мэдээлэл харилцаа холбооны технологийн бүх компанитай бид хамтран ажиллаж, ирэх 20 жилд учрах сорилттой нүүр тулахыг гэсэн ядан хүлээж байна. Мөн Мобикомын бүх хамт олны зүгээс та бүхэнтэй ирэх жилүүдийн аян замын турш хамт байж, боломжтой хамгийн өндөр стандартын дагуу та бүхэнд үйлчилнэ гэдэгт итгэж болно гэдгийг хэлмээр байна. Та бүхэндээ Мобиком корпорацийн 20 жилийн ойн баярын мэнд дэвшүүлье. ■

МобиКом

ТОВЧООН



Монгол Улсад үүрэн холбооны анхны оператор компани үүсэн байгуулагдлаа.

1996 он

2000 он

МобиКомын хэрэглэгчид гадаадад гар утсаараа ярьдаг болов. Мобифоны цагаан утас болон мессеж үйлчилгээг нэвтрүүлэв.

2005 он

Гар утсаараа интернэтэд холбогддог боллоо.

2007 он

Хувь Банк

Mobile банк үйлчилгээг нэвтрүүлэв.

2008 он

Залууст зориулсан Be брэнд нэвтрүүлэв.

2009 он

3.5G үйлчилгээг нэвтрүүлэв. Дүрсээ харж ярьдаг боллоо.

2009 он

МобиКом 1 сая хэрэглэгчтэй боллоо.

2009 он

Бяцхан хэрэглэгчдэд зориулан Старс үйлчилгээг нэвтрүүлэв.

2011 он

МобиКом Корпорацийн 15 жилийн ойн далбаа дэлхийн зулай Эверестийн ноён оргилд мандлаа.

2011 он

ISO 9001:2008 төслийг амжилттай хэрэгжүүлж, Монгол Улсын харилцаа холбооны салбарт анх удаа олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдлөө.

2011 он

Дэлхийн супер од Дуайт Ховард МобиКом группийн урилгаар Монгол Улсад хүрэлцэн ирэв.

2011 он

SAMSUNG-ийн гар утсыг Монгол Улсад албан ёсоор борлуулж эхэллээ.

2012 он

3.5G сүлжээг Монгол орон даяар нэвтрүүлэв.

2012 он

Монголд анх удаа Apple-ын iPhone утсыг албан ёсоор худалдаж эхэллээ.

2013 он

2013 он

Candy хөтөлбөр нэвтрүүлэв.

2014 он

2015 он

Монгол Улсад анх удаа дараа болон урьдчилсан төлбөрт үйлчилгээг хослуулсан "HYBRID" багц нэвтрүүлэв.

2015 он

Монголд анх удаагаа бүх операторын хэрэглэгчид үнэ төлбөргүй ашиглах боломжтой Мобинет WiFi интернэт үйлчилгээг нэвтрүүлэв.

2015 он

Монголын анхны газар зүйн нөөц дата төв байгуулагдлаа.

2015 он

Өндөр хурдны 4G LTE үйлчилгээг нэвтрүүлэв.

2016 он

Бүх операторын хэрэглэгч iPhone гар утсыг авах боломжтой боллоо.

МобиКомын 20 жилийн ой үргэлжилсээр...

Apple iPhone 7



Монголд АЛБАН ЁСООР...





2017.01.01-нээс захиалгын үнэ

~~15.000₮~~
10.900₮



Нийгмийн хариуцлага

Хүүхэд төвтэй нийгмийн хариуцлага

Г.ДАВААДОРЖ

Монгол орны хамгийн эрсдэлтэй нөхцөлд байгаа зүйл юу вэ? Төгрөгийн ханш уу, уул уурхайн салбар уу, эсвэл эдийн засаг уу? Эдгээрийн аль нь ч биш.

Хамгийн их эрсдэлтэй тулгарч буй зүйл нь Монголын ирээдүй юм. Хүүхэд багачууддаа бараг анхаарал тавьдаггүй орнуудын нэг нь Монгол гээд хэлчихэд хол зөрөхгүй болов уу. Хүүхдүүд гэртээ, гудамжинд, сургууль дээрээ эрүүл мэнд, оюун санааны хохирлыг өдөр бүр, алхам тутамдаа амссаар байна.

Монголын ирээдүйд аюул занал учруулж буй томоохон асуудлуудын нэг нь модон жорлон юм. Модон жорлон Улаанбаатарын хөрсний бохирдлын 90 хувийг эзэлж, гэр хороолол, сумдын сургуулийн мянга мянган багачууд гэдэсний халдварт өвчин тусах гол шалтгаан болж байна. Ялангуяа зуны улиралд модон жорлон нь цусан суулгалт, вирус гепатит А, Б, интервирусийн халдварт өвчнүүд дэлгэрэх эх үүсвэр болдог. Эдгээр өвчинд хамгийн өртөмтгий эмзэг хэсэг нь бага насны хүүхдүүд бөгөөд тэд өвлийн цагт халтиргаанаас үүдэн гэмтэж бэртэх, мөн охид доороосоо даарснаас болж эмэгтэйчүүдийн өвчнөөр өвчлөх гол шалтгаан болдог гэж ХӨСҮТ-ийн их эмч С.Гамуу ярилаа.

Олон жил зөвхөн хэлэлцүүлгийн сэдэв байсаар ирсэн модон жорлонгийн асуудал одоогоос хоёр жилийн өмнө бодит ажил болон хэрэгжиж эхэллээ. Гэхдээ модон жорлонг цөөлөх үндэсний хэмжээний кампанит ажлыг төр биш, хувийн хэвшил эхлүүлсэн нь манай улсад компанийн нийгмийн хариуцлагын тухай ойлголт өндөр түвшинд хөгжсөний нэгэн илрэл болж байна.

Мобиком Монголын үүрэн холбооны салбарт хамгийн ууган хувийн компани болохын хувьд хүүхэд багачууд бохир, агааржуулалтгүй, модон жорлон ашиглаж байгааг зүгээр хараад суусангүй. 2014 оноос тус корпораци Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Сумдын сургуулийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах төсөл” хэрэгжүүлж эхэлжээ. Энэ төслийн хүрээнд гурван жилд нийт 12 аймгийн 35 сумын сургуульд чанар, стандартын шаардлага

хангасан ариун цэврийн байгууламж барьж өгсөн байна. Сургуулиас тодорхой зайд байрлах ёстой, септик технологийн дагуу барьсан эдгээр ариун цэврийн байгууламж нь боловсон суултууртай, халуун хүйтэн устай, усанд орох боломжтойгоороо онцлог. Газрын гүний усыг халааж, усаар хангадаг бөгөөд хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашигладаг, хуримтлагдсан лагийг гурван жилд нэг удаа соруулах зориулалттай нь хөдөө орон нутагт маш тохиромжтой шийдэл аж.



Хөдөөд 35.000 хүүхэд орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангагдаад байна.

2016 оны есдүгээр сарын байдлаар төвөөс алслагдсан сумдын сургуулийн нийт 35.000 хүүхэд орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангагдаад байна. Одоогийн байдлаар Төв аймгийн Аргалант сумын сургууль дээр уг байгууламжийн барилгын ажил явагдаж байна.

Төсөл хэрэгжсэн эхний жилд Мобиком корпораци санхүүжилтийн 70 хувийг, Дэлхийн зөн Монгол 30 хувийг гаргаж байв. Харин 2015 оноос орон нутгийн удирдлагыг татан оролцуулах болсноор гурван тал төслийн санхүүжилтийг тус бүр 33 хувиар хариуцдаг болжээ. Мөн МҮОНТ, НҮБ-ын Хүүхдийн сан, Роял Кинг барилгын компаниуд төсөлд нэгдэн орсноор энэ ажил улам эрчээ авч байна. Мобиком 2014-2015 онд уг төсөлд нийт 1,2 тэрбум төгрөг зарцуулжээ. ▶

► Мобикомынхон 2017 онд дор хаяж 10 сумын сургууль, боломжтой бол 20 сумын сургуулийн модон жорлонг халах төлөвлөгөөтэй байгаа гэж Мобиком корпорацийн Олон нийт, хамтын ажиллагааны газрын захирал Э.Чинзориг хэллээ.

Нийгэмд хурцадсан асуудлыг зоригтой сонгон авч, үндэсний хэмжээний кампанит ажил болгож чадсан Мобикомын хувьд энэ ажил нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдээс хамгийн том үр дүн авчирсан төсөл юм.

Мобиком 2014 онд нийгмийн хариуцлагын



Хүүхдийн тусламжийн утас 108-ыг 24 цагаар ажиллуулдаг.

бодлогоо шинэчлэн баталж, Олон нийт, хамтын ажиллагааны газрын хүрээнд тусгай алба бий болгосон байна. Энэ бодлогод тусгаснаар “компанийн нийгмийн хариуцлага гэдгийг зөвхөн тухайн компанийн нийгэм, хамт олны өмнө хүлээсэн хариуцлага, бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа баримталдаг зарчим гэдгээр ойлгож болохгүй бөгөөд энэ нь өөрийн хөгжил цэцэглэлтээс гадна нийгмийн төлөө, хүмүүсийн сайн сайхан амьдралын төлөө санаа тавьдаг компанийн бизнес, нийгмийн үйл ажиллагааны философи” ажээ.

Мобиком корпорацийн хувьд энэ философийн цөм нь хүүхэд юм. Тиймээс Мобиком нь нийгмийн хариуцлагыг зүгээр нэг хэрэгжүүлэгч бус, санаачлагч, бас манлайлагч гэж тодорхойлбол зохилтой.

Хүүхэд таныг сонсож байна

Тус корпорацийн хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй нэгэн том ажил бол “Хүүхдийн тусламжийн утас 108” төсөл юм. Энэ төсөл хэчнээн чухал болохыг, манай улсад хүүхдийн эрхийн зөрчил ямар их газар авсныг сэтгүүлч миний бие энэхүү материалыг бэлдэж явахдаа олж мэдсэн юм.

Монгол Улс НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2001 оноос хүүхдийн

тусламжийн утас ажиллуулж эхэлсэн ч төсөв мөнгөний гачигдлаас болж өргөн хүрээг хамарч чадахгүй байв.

2014 оноос Мобиком “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын /хуучнаар ХТҮГ/ дэмжлэгтэйгээр хүүхдийн тусламжийн утсыг шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тогтоолоор 108 дугаартай хүүхдийн тусламжийн утсыг яаралтай тусламж үйлчилгээний ангилалд шилжүүлэн үүрэн болон суурин утасны орох дуудлагын үнийг чөлөөлжээ.

Мобикомын зүгээс тусламжийн утасны бүх техник, программ хангамжийн асуудлыг 100 хувь хариуцаж, өөрийн серверийг үнэгүй ашиглуулж байна.

Хүүхдийн тусламжийн утас нь долоо хоногийн 24 цагт дөрвөн ээлжээр 16 зөвлөгч, дөрвөн нийгмийн ажилтан, нэг ахлах сэтгэл зүйч, нэг зохицуулагч, нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Улсын хэмжээнд 152 хороо, 336 сумын хүүхэд хамгаалах хамтарсан баг, 21 аймаг, есөн дүүргийн хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс, сургууль, цэцэрлэгийн удирдлага, нийгмийн ажилтан, орон нутгийн ЗДТГ, ИТХ болон бусад ТББ, олон улсын байгууллагатай холбогдон ажилладаг аж.

Хүүхдийн тусламжийн утас 108 нь дунджаар өдөрт 430, сард 13.200 дуудлага хүлээн авч, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд асуудлыг холбогдох байгууллагад шилжүүлдэг. Ийнхүү хоёр жилийн хугацаанд нийт 360.000 дуудлага бүртгэжээ. Үүнээс 5000 дуудлага нь хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах яаралтай тусламж шаардсан дуудлага байсан тухай “108 хүүхдийн тусламжийн утасны дуудлагын үйлчилгээний төв”-ийн мэргэжилтэн М.Энхболд ярилаа.

Мобикомынхны хүүхдийн төлөө хийдэг ажил үүгээр хязгаарлагдахгүй. Шинэ төсөл хэрэгжих бүрт нийгмийн хариуцлагын бодлого шинэ агуулгаар баяждаг. Тэдний санаачилсан зарим төсөл, хөтөлбөр төрийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгалаа олжээ. Тухайлбал, Мобиком “Үдийн цай” хөтөлбөрийг анх хотын захад байрлалтай 12 сургуулийн 1-2 дугаар ангийн сурагчдын дунд хэрэгжүүлснээр хичээл таслалт, сургууль завсардалт багасаж, сурагчдын хичээлийн идэвх нэмэгдсэн зэрэг олон эерэг үр дүн авчирсан байна. Энэ ажлыг тухайн үеийн Засгийн газар дэмжиж “Үдийн цай” хөтөлбөрийг орон даяар хэрэгжүүлж эхэлжээ.

Нийгмийн хариуцлагын ажил бол Мобикомын хамт олны гол бахархдаг зүйл гэж Э.Чинзориг ярьсан нь үндэслэлгүй хэлсэн үг биш гэдэг нь ийнхүү харагдаж байна. ■

Тоон мэдээ

Мобиком компани нийгмийн хариуцлагын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлыг тоон дүнгээр сонирхуулж байна.





Үйлчилгээ

Хэрэглэгчдийг холбох гүүр

М.БИЛГҮҮН

Үйлчлүүлэгчдийнхээ санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж чадсан байгууллага л салбартаа тэргүүлдэг. Энэ бол зах зээлийн эдийн засгийн хууль. Энэ ч утгаараа Монголын үүрэн холбооны салбарт тэргүүлэгч нь Мобиком корпораци юм.

Мобиком корпораци, хэрэглэгч хоёрыг холбож өгдөг гүүр нь Үйлчилгээний нэгдсэн төв буюу та бидний мэдэх 2222 лавлах төв юм.

Мобиком корпораци нь хамгийн анх 312222 лавлах шугамын үйл ажиллагааг эхлүүлж байсан бөгөөд 2005 оноос эхлэн өнөөдөр та бидний сайн мэдэх 2222 “Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан Мобикомын 1.3 сая хэрэглэгчдэдээ үнэ төлбөргүй үйлчилж байна.

Хэрэглэгч шинэ бүтээгдэхүүн, урамшууллын талаар лавлагаа авах, нэмэлт үйлчилгээ идэвхжүүлэх, санал хүсэлтээ өгч шийдвэрлүүлэхээс гадна өөрсдөө хэрэглэгчтэйгээ утсаар холбогдон хэрэгтэй мэдээ, мэдээлэл хүргэх, хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг судлах, түүндээ тулгуурлаж үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх замаар хэрэглэгчтэйгээ байнгын эргэх холбоо үүсгэн, байгууллага болон хэрэглэгчийнхээ хооронд гүүр нь болж ажилладаг байна.

Та 2222 дугаарт дуудлага хийснээр Мобикомын бүх төрлийн үйлчилгээ болон бүтээгдэхүүний лавлагааг долоо хоногийн 24 цагийн аль ч үед авах боломжтой.

Олон улсын жишигт нийцсэн 2222 “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн автомат хариулагчаас Мобиком групп компаниудын бүхий л үйлчилгээг Монгол, Англи хэлээр авах боломжтой.

Мобикомын дугаараас Үйлчилгээний нэгдсэн төв - 2222 дугаарт үнэ төлбөргүй, бусад үүрэн болон суурин холбооны хэрэглэгчид 1800-2222 дугаарт энгийн утасны тарифаар холбогдон хүссэн мэдээллээ авч, үйлчлүүлэхийг урьж байна. Мөн гадаадад Мобикомын олон улсын роуминг үйлчилгээг ашиглаж байгаа хэрэглэгч дэлхийн аль ч орноос 1800-2222 лавлах дугаарт хандан үнэ төлбөргүй мэдээллээ авах боломжтой.

Үйлчилгээний нэгдсэн төв нь үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд хэрэглэгчийн холбогдох хугацаа, эхний хандалтаар асуудлыг шийдвэрлэх хувь гэх мэт олон улсын хэмжүүр үзүүлэлтээр үйл ажиллагаагаа хэмжиж, хэрэглэгчдэдээ энгийн, найрсаг, хурдан шуурхай үйлчлэхийг зорин ажилладаг. ▶

► Диллер буюу гэрээт борлуулагч

Мобиком корпораци нь үйлчилгээгээ хэрэглэгчдэд улам ойртуулах зорилгоор монгол орны өнцөг булан бүрт байрлах 10 мянга орчим диллерээрээ дамжуулан хэрэглэгчдэдээ улам ойртон ажиллаж байгаагийн дээр гэрээт борлуулагчаар дамжуулан үйлчилгээгээ хүргэж, хэрэглэгчдийнхээ лавлагаа мэдээлэл, санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэж ажиллаж байна.

Дэлхийн хаанаас ч холбогдох боломжтой сувгууд

Олон нийтийн сүлжээ нь сүүлийн үед албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хэрэглэгчтэйгээ шууд харилцдаг хамгийн том суваг болоод байгаа билээ. Мобикомын хувьд албан ёсны вэб хуудас болон Facebook, Twitter, Youtube, instagram, linkedin зэрэг олон нийтийн сүлжээгээр хэрэглэгчдийнхээ санал хүсэлтийг шуурхай хүлээн авч холбогдох арга хэмжээг авдгаараа бусад газруудаас онцлог давуу талтай. Өнөөдрийн байдлаар Мобикомын Facebook хуудас Монголын хамгийн олон дагагчтай болж хэрэглэгчдийн хандалт, like, share-ийнхээ тоогоор нэгдүгээрт бичигдэж байна. Сошиал хуудсуудад хандсан хэрэглэгчдийн хандалт бүрт хамгийн богино хугацаанд хариулт өгдгөөрөө Мобикомын хамт олон бусдад үлгэрлэх хэмжээнд хүрчээ.

Сардаа нэг сая гаруй иргэний санал гомдол хүлээн авч шийдвэрлэдэг 2222 төвд 200 гаруй ажилтан ажиллаж, хүчирхэг системээс гадна чадварлаг хамт олны зүтгэлээр хэрэглэгчдэд ойр ажиллах боломж бүрддэг. Өөрөөр хэлбэл, монгол орон даяар тархан суурьшиж байгаа нэг сая 300 мянган үйлчлүүлэгчийг хамарсан өргөн сүлжээг хянах хүнд бөгөөд хүндтэй үүргийг Хэрэглэгчийн үйлчилгээний газрын Үйлчилгээний нэгдсэн төвийн хамт олон хариуцан ажиллаж байна.

Тус төв ойрын хугацаанд иргэдээс ирсэн санал, хүсэлтийн дагуу доорх асуудлуудыг шийдвэрлэжээ.

- Урьдчилсан төлбөрт хэрэглэгчийн гар утасны хугацаа дуусна гэж санаа зовох шаардлагагүй болжээ. Тус төвд ирсэн иргэдийн хүсэлтээр дугаарын хугацаа дуусдаг байсныг өөрчилсөн байна. Хэрэглэгч дугаараа идэвхтэй байлгахын тулд байнга ашиглаж байх шаардлагатай.
- Иргэдийн санал хүсэлт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан 4G үйлчилгээг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн интернэт хэрэглээ өсөж байгаатай холбоотойгоор олон төрлийн дата сонголт, дата урамшуулал санал болгож байгаа.
- Дараа төлбөрт хэрэглэгчдийнхээ санал хүсэлтэд тулгуурлан өөрийн хүссэнээр багцаа сонгон ашиглах боломжтой Миний Моби үйлчилгээг шинээр зах зээлд нэвтрүүлсэн.

Тус хамт олон хэрэглэгчийн итгэлийг эрхэмлэн, “Хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, хэрэглэгчдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх”-ийг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажиллаж байна. ■

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

-Та яагаад Мобикомыг сонгодог вэ?

Д.Жаргалсайхан (Дараа төлбөрт хэрэглэгч):

-Компанийнх нь алсын хараа таалагдсан, бас түүнийгээ хэрэгжүүлж чадна гэж найддаг учраас би хэрэглэгч нь болсон. Цаашид манайд нийгмийн итгэлцлийг бий болгоход харилцаа холбооны салбарын үүрэг маш чухал. Мобикомыг энэ чиглэлд амжилт гаргахыг хүсье!

Б.Оюунжаргал (Дараа төлбөрт хэрэглэгч):

-Би Мобикомын ерээд оны хэрэглэгч. Энэ хугацаанд оператороо нэг ч удаа сольсонгүй. Тийм болохоор энэ байгууллагын үнэнч хэрэглэгч гэж өөрийгөө боддог. Учир нь тус компанийн үндсэн технологи нь чанартай. Тэр ч үүднээсээ харилцааны хэрэгслийн үүргээ сайн биелүүлдэг. Түүнчлэн бусад оператораа бодоход хэрэглэгчдийн цаг завьг хэмнэх тал дээр санаачилгатай ажилладаг.

Мөн хэрэглэгчдээ хүндэтгэлтэй ханддаг. Тухайлбал, төлбөр төлөх хугацаа болсон байвал шууд салгалгүй, үйлчлүүлэгчид эхлээд заавал мэдэгддэг. Үйлчилгээний соёлыг эрхэмлэн ажилладаг нь аль ч салбарт нь очиход мэдрэгддэг.

А.Булган (Урьдчилсан төлбөрт хэрэглэгч):

-Миний утасны дугаар 9919...тэй. Мобикомын хамгийн анхны дугаарт орох байх. Анх намайг нэгдүгээр ангид орох үед аав энэ дугаарыг авч өгч байсан. Энэ жил би их сургуулиа төгсөнө. Арван дөрөв дэх жилээ барьж байна. Энэ хугацаанд нэг бус удаа утсаа сольсон ч дугаараа нэг ч солиогүй. 4G нэвтрүүлэх болсонд баяртай байгаа.

С.Цолмон (Урьдчилсан төлбөрт хэрэглэгч):

-Анх их сургуульд орохдоо Мобикомын 9912-той дугаар авч байсан. Оюутан байхдаа утсаар ярихаасаа илүү мессеж бичдэг байлаа. Оюутан цагийн олон дурсамж энэ дугаартай холбоотой. Өнөөдөр ч оюутан цагийн найзуудтайгаа энэ дугаараараа холбогддог.

А.Ариундалай (Дараа төлбөрт хэрэглэгч):

-Би Мобикомын 9911-тэй дугаарын хэрэглэгч. Гадаад харилцааны менежерийн ажил эрхэлдэг. Өнөөдөр гар утас хэрэглээ төдийгүй хувь хүнийг илэрхийлэх имиж болжээ гэж боддог. Тэр ч утгаараа энэ дугаар ажил хэрэг явуулахад хамгийн чухал хэрэгсэл төдийгүй намайг илэрхийлэх нэрийн хуудас юм. ■



ТВ СУВАГ,
ШОУ НЭВТРҮҮПЭГ,
ШИПДЭГ КИНОНУУДЫГ
ХЭЗЭЭ 4 ХААНААС 4*...




 App Store

 Play Store

 www.mobiplay.mn

 2222

 1800-2222 | бусад
сүлжээнээс

*Гадаад контентууд болон ТВ сувгуудыг
зөвхөн Монгол Улсаас үзэх боломжтой

Бүтээгдэхүүн

Моод Монголоор дуусдаггүй

М.БИЛГҮҮН

Моод Монголоор дуусдаггүйг Мобиком багалсаар байна. Тус корпораци 20 жилийн турш техник технологийн хөгжил, цаашдын чиг хандлагыг соргогоор мэдэрч, ард түмэндээ түгээх үйлсийг түүчээлсээр ирсэн. Ирээдүйг иргэд, үйлчлүүлэгчдэдээ ойртуулж байдгийн жишээ болгон “Candy” хөтөлбөр болоод Mobipay үйлчилгээнүүдийг онцолж байна.

Илүү амттай лоялти хөтөлбөр буюу илүү ашигтай цахим мөнгө

Техникийн дэвшил хүмүүсийн амьдралын хэв маяг төдийгүй уламжлалт хэрэглээг өөрчилж байна. Ойрын ирээдүйд төлбөр тооцооны багаж хэрэгсэл ч өөрчлөгдөх хандлага ажиглагдах болов. Гар утсаараа төлбөр, тооцоо хийх хялбар систем дэлхий дахинд эрчимжиж байна. Бизнесийн байгууллагууд хэрэглэгчдэдээ улам ойртож тэдний анхаарлыг татаж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх төрөл бүрийн урамшууллуудыг санал болгож байна. Хэрэглэгчдэдээ урамшууллыг хэрхэн шуурхай хүргэх, бусдаас яаж өрсөх, хэрэглэгчдэд таалагдах шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн бий болгох, хэрэглэгчээ яаж таних, тэдний дахин дахин худалдан авалт хийх сонирхлыг хэрхэн төрүүлэх вэ гэхчлэн олон олон асуулт тэдэнд тулгардаг. Нөгөө талаас хэрэглэгчид ч өөрт илүү таатай боломжуудыг байнга эрэлхийлж, нэгэнт хэрэглэж дадсан үйлчилгээгээ өдөр тутам түргэн шуурхай, хялбар аргаар худалдан авахыг хүсдэг.

Энэ бүхнийг нэгэн дор бүрдүүлж, техникийн дэвшлийг цаг алдалгүй нэвтрүүлэгч Мобиком корпораци Монголд анх удаа цахим төлбөр тооцоо болоод урамшууллын систем-Candy хөтөлбөрийг зах зээлд амжилттай байршуулсан ба өдгөө 1,2 сая хэрэглэгчтэй Монголын хамгийн том лоялти хөтөлбөр болон өргөжжээ.

Candy-г энгийн үгээр илэрхийлбэл, байнга үйлчлүүлдэг байгууллагуудаас худалдан авалт хийх бүрдээ candy цуглуулах, цуглуулсан candy-гээ дараагийн худалдан авалтанд ашиглахдаа гар утсан дахь цахим дансаа ашиглан төлбөр тооцоогоо гүйцэтгэх, төрөл бүрийн хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах боломжийг Танд олгосон цогц систем юм.

Энэхүү хөтөлбөр нь төлбөр тооцооны цахим хэлбэрийг Монгол Улсад хөгжүүлэх эхний алхам болж байгаагаараа онцлогтой. Зөвхөн худалдан авагчид биш бизнесийн бүх төрлийн байгууллагуудад борлуулалтаа нэмэгдүүлэх боломж олгодгоороо хэрэглэгчдийн анхаарлыг улам татсаар байна. Аливаа байгууллага Candy-д нэгдсэнээр илүү олон үйлчлүүлэгчдэд өөрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох боломжтой болно.

Candy хөтөлбөр одоогийн байдлаар 4500 гаруй аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. Тэдний үйлчлүүлэгчдийн хувьд бараа, үйлчилгээний сонголт нэмэгдэх, худалдан авалтаасаа хөнгөлөлт эдлэх, candy цуглуулах зэрэг давуу талтай юм.

Төлбөр тооцооны энэхүү цахим чиг хандлага эдийн засгийн хамгийн энгийн харилцаанд хэрэглэгдэж, хэрэглэгчид хэрэглэж сурсан мессеж үйлчилгээгээр дамжуулан, вэб хуудсанд зочилж, хамтрагч байгууллагуудын дэлгүүрээс худалдан авалт хийх гэх мэт хялбар аргаар төлбөр тооцоогоо гүйцэтгэж байна.



Таны сар тутмын хэрэглээний төлбөр тооцоо

Сар тутамд бидний хийдэг эдийн засгийн харилцааны нэг хэлбэр бол орон сууц, тог цахилгааны болон гар утасны хэрэглээний төлбөр тооцоо юм. Candy-гийн хэрэглэгчид цуглуулсан Candy-гээрээ УБЦТС ТӨХК-ийн mytog.mn вэб ▶

► сайтаар дамжуулан цахилгааны төлбөр болон гар утасны төлбөр тооцоогоо Candy-гээрээ хялбар, шуурхай төлж буй нь ихээхэн талархал хүлээгээд байна.

Ухаалаг худаг

Улаанбаатар хотын хүн амын талаас илүү хувь нь гэр хороололд амьдардаг бөгөөд гэр хорооллын иргэд ундны усаа худгаас худалдаж авдаг. Ус сувгийн удирдах газраас 2015 оноос эхлэн “Ухаалаг худаг” төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төсөл Candy хөтөлбөртэй хамтран ажилласнаар иргэд худгаас ундны ус авахдаа бэлэн мөнгө зарцуулахгүйгээр candy-гээрээ авах таатай боломж бий болсон. 1 Candy нь 1 литр устай тэнцдэг.

Илүү амттай хөнгөлөлт урамшууллууд

Candy хөтөлбөрт нэгдэж бидэнд илүү амттай хөнгөлөлт урамшууллуудыг санал болгож буй олон байгууллага бий. Хэрэглэгч та Мобикомоос илүү амттай Candy санал хүлээж авахын зэрэгцээ Моносын эмийн сангаар үйлчлүүлэхдээ, Петровис ШТС-аас бензин худалдан авахдаа, гэрийнхээ ойролцоох жижиг хүнсний дэлгүүрээс талх сүү гэх мэт дурын бүтээгдэхүүнээ авахдаа, Өргөө, Гэгээнтэн кино театрт кино үзэхдээ, Монгол даатгал компанид автомашинаа даатгуулахдаа, Coffee bean-д саатахдаа, Pepsi, Vitafit ундаа уухдаа, Round table & Dodo pizza-гаар үйлчлүүлэхдээ, California fitness, Elit gym-д хичээллэхдээ, Get болон Genius гадаад хэлний сургалтын төвд сурахдаа гэхчлэн өдөр тутмын хэрэглээний худалдан авалт бүртгээ candy-г ашиглаж орчин үеийн хэмнэлтэй хөл нийлүүлэн алхахыг уриалж байна. Танд таалагдах нь дамжиггүй.

mobiPLAY таны амьдралд өнгө нэмнэ

Зурагтыг зөвхөн зурагтаар үзэх шаардлагагүй болжээ. Дуртай нэвтрүүлгээ гараад дуусчих вий гэж эмээх ч хэрэггүй. Гэр бүлийн гишүүн бүрийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон нэвтрүүлгийн сангаас дуртайгаа сонгож үзэх боломжтой болжээ. Мэдээллийн хамгийн хүртээмжтэй суваг болох цэнхэр дэлгэц дэлхий дахинд ийн хувьсан өөрчлөгдөж байна. Харин Монголын хэрэглэгчдэдээ дэлхийтэй хөл нийлүүлэн алхах боломжийг Мобиком корпораци олгож байна. Энэ бол mobiPLAY үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээ таны амьдралд өнгө нэмэхээс гадна гэр бүлд тань халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх болно.

Өмнө нь телевизийн хөтөлбөрүүдийг “цэнхэр


дэлгэц”-ээр хүлээн авдаг байсан бол одоо “ухаалаг дэлгэц”-ээр хүлээн авах боломжтой болжээ. Энэхүү үйлчилгээг ашигласнаар телевизийн контентуудыг компьютер, гар утас, таблет зэрэг төхөөрөмжөөр, хэзээ ч, хаана ч үзэх боломж нээгдэх юм. mobiPLAY үйлчилгээ нь интернэтийн орчинд хүссэн контентоо үзэх боломж олгох ба та гадаад, дотоодын хамгийн өндөр рейтингтэй 28 сувгийг дуу, дүрсний өндөр чанартайгаар үзэх боломжтой.

Уламжлалт телевизийн хөтөлбөр нь нэг гараад өнгөрвөл дахин үзэх боломжгүй тул саяхныг хүртэл тухайн мөчид нь л анаж үзэх нь алдаж болшгүй ганцхан боломж байв. Харин mobiPLAY үйлчилгээг ашигласнаар дуртай нэвтрүүлгээ та гурав хоногийн дараа хүртэл нөхөж үзэх боломжтой. Нөхөж үзэх энэхүү үйлчилгээг зөвхөн телевизийн хөтөлбөрөөр хязгаарлаж болохгүй юм. Телевизийн хөтөлбөрөөс гадна видео контентуудаас хүссэнээ сонгон үзэх боломжтой. mobiPLAY нь HBO, Cartoon network, Discovery, Warner Bros, Universal, Paramount зэрэг дэлхийн брэндүүдтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд хэрэглэгч та 1600 цагийн багтаамжтай сангаас хүссэн кино, контентоо сонгон үзэх боломжтой юм. Мөн дэлхийн шилдэг кинонуудыг монгол орчуулгагай, мэргэжлийн дуу оруулалттай хүргэдэг нь энэхүү үйлчилгээний бас нэгэн давуу тал билээ.

Телевизийн хамгийн үнэнч үзэгчид нь хүүхдүүд байдаг. Бага ангийн сурагчдын дунд явуулсан судалгаагаар хүүхдүүд өдөрт дунджаар 2-3 цагийг зурагт үзэхэд зарцуулдаг нь тогтоогдсон. Бизнесийн байгууллагууд ч бяцхан хэрэглэгчдийг өөртөө татахыг хичээх болсон. Тэгвэл Мобиком

корпораци нийгмийн хариуцлагаа ухамсарлан mobiPLAY үйлчилгээндээ хүүхдэд чиглэсэн бүтээгдэхүүн түлхүү оруулаад байна. Зөвхөн хүүхэддэй кино төдийгүй хүүхдийн хүмүүжил, боловсролд тохирсон сонирхолтой нэвтрүүлэг, танин мэдэхүйн цуврал кинонуудыг түлхүү оруулахыг зорьж байгаа аж. mobiPLAY үйлчилгээний бусдаас ялгарах давуу тал нь чанар болоод хамгаалалт юм. Хүсвэл та хамгаалалтын тохиргоо хийх боломжтой бөгөөд ингэснээр хүүхдийнхээ нас, сэтгэхүйд тохирсон нэвтрүүлгүүдээс сонголт хийж, үзэж буй зүйлд нь хяналт тавих бололцоотой.

mobiPLAY үйлчилгээний хэрэглэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар 30 мянган хүн идэвхтэй үйлчлүүлж байна. Харин Мобикомын хамт олон ойрын хугацаанд 180 мянган хэрэглэгч татах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ажээ. Иймээс тэд сар, улирал бүр сонирхолтой урамшууллууд зарлаж байгаа бөгөөд хямд үнэ, чанартай контентууд нийлүүлж, шинэ хэрэглэгчдэдээ эхний гурван сар үнэгүй ашиглах эрх, шөнийн цагаар mobiPLAY апплейшн үнэ төлбөргүй ашиглах боломжуудаар бэлэг барьсаар байна. ■



candy®

ИЛҮҮ АМТТАЙ ЛОЯАЛТИ ХӨТӨЛБӨР

Хэрэглэгч

Хоног сунгалтыг март

Г.ДАВААДОРЖ

Шалихгүй зүйл заримдаа ажил хэрэгт маш том саад болдог эгзэгтэй нөхцөл амьдралд цөөнгүй бий. Ялангуяа урьдчилсан төлбөрт хэрэглэгчдийн дунд. Тухайлбал, та хотоос орон нутаг руу гарахын өмнө хэн нэгэн рүү залгаж, чухал ажил утсаараа

хүүхэд эсвэл өөрийн тань шуурхай нэгж, sandy-г аль хэдийнэ ашиглачихсан. Буцаад хот руу орох хэцүү. Нөгөө талаас энэ хүн рүү одоо л залгахгүй бол хэсэг хугацааны дараа холбогдох боломжгүй болох учраас ацан шалаанд ордог.

Тэгвэл Мобиком саяхнаас хоног сунгалтыг халж, тухайн хэрэглэгч нэгжтэй л бол дуудлага хийх боломжийг нээжээ.

Интернэт үнэгүй

Гар утас зөвхөн ярих, мессэжээр харилцах хэрэгсэл байхаа больжээ. Гар утас өнөөдөр мэдээлэл хүлээн авах, түгээх, банкны төлбөр тооцоо хийх, интернэтээр дэлхийн хаана ч байгаа хүнтэй холбоо тогтоох, найз нөхөдтэйгөө харилцах, түүгээр барахгүй худалдан авалт хийх, нэг үгээр хэлбэл, орчин үеийн хүн бүрийн гар доорх хүчирхэг зэвсэг болж хувирсан. Энд гол үүрэг гүйцэтгэдэг зүйл бол бидний нэрлэж заншсанаар дата буюу тодорхой хугацаанд гар утсаар интернэтэд холбогдож ихэвчлэн мегабайт, гигабайтаар хэмжигдэх мэдээлэл солилцох эрх юм.

Дата хэрэглээний хувьд хоног сунгалтын нэгэн адил эгзэгтэй нөхцөлүүд үүсдэг. Найзтайгаа чатаар чухал яриа өрнүүлж байтал гэнэт дата дуусч килобайт тутмыг есөн төгрөгөөр тооцоод эхлэхэд хэн ч гэсэн интернэтээ хаахаас өөр аргагүй болдог.

Харин Мобиком энэ сараас эхлэн “Миний Моби” үйлчилгээний багцын хэрэглэгчдэдээ зориулж дата багцын эрх нь дууссан ч задгай хэрэглээнд төлбөр тооцоохгүй байх таатай нөхцөл шинээр бүрдүүлээд байна. Тиймээс “Миний Моби” багцын хязгааргүй ярих ▶

амжуулах гэтэл хоногоо сунгуулаагүй учраас гадагшаа дуудлага хийх боломжгүй болчихсон гэж бодъё. Ганцаар яваа учраас өөр хүний утас гуйж чадахгүй. Хотын захад яваа учраас ойролцоо нэгж зарах цэг байхгүй. Түүнээс гадна таны



▶ болон хязгааргүй мессэж бичих эрх сонгосон хэрэглэгчид дата эрхгүй байсан ч 128Kbps хурдаар интернэтээр чөлөөтэй аялах боломжтой болжээ.

“Миний Моби” багц хэрэглэгчдээ “эрхлүүлж” байна

Өнөө цагийн хэрэглэгч амьдралынхаа багагүй хэсгийг гар утасны яриа, мессэж, интернэт гэсэн гурван зүйлд зарцуулдаг гэвэл буруудахгүй. Компанийн захирлууд, менежерүүд, олон нийттэй харилцах ажилтнуудын хувьд утсаар ярина гэдэг бараг амьсгалахтай адил чухал зүйл болоод байна. Тэдний хувьд нэгж, цэнэг дуусах нь сүйрэл авчирдаг.

Харин гар утсаа ашиглан цахим орчинд өдөр тутмын ажлаа хийдэг сэтгүүлчид, хувийн блог хөтлөгчид, жиргээчид, фэйсбүүкчид, интернэтэд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг залуучуудын хувьд дата дуусвал гэрэл унгарч харанхуй нөмрөхтэй адил.

Тиймээс үүрэн телефоны операторууд хэрэглэгчдэдээ зориулж дата хэрэглээний төрөл бүрийн хувилбар санал болгодог билээ.

Мобиком корпорацийн хувьд энэ чиглэлээр маш оновчтой шийдэл олсон байна. Тэд дараа төлбөрт хэрэглэгчдэдээ зориулан үүрэн холбооны салбарт анх удаагаа хэрэглээгээ өөрөө сонгодог “Миний Моби” багц нэвтрүүлсэн нь “Та бүтэн сарын турш хязгааргүй яримаар байвал ярь, илүү бичмээр байвал бич эсвэл датагаа түлхүү хэрэглэмээр байвал хэрэглэ, та өөрөө сонго” гэсэн уян хатан, шинэлэг үйлчилгээ болж хэрэглэгчдээсээ ч талархлын үг харамгүй сонсоод байгаа ажээ.

“Миний Моби” багцын үйлчилгээг сонгосон хэрэглэгч хэрэглээ, сонирхол, төлбөрийн боломжоо харгалзаж үзээд долоон янзын үйлчилгээний эрх, 31 төрлийн сонголтгоос зөвхөн өөртөө тохирох хувилбарыг гаргаж авна. Ийм уян хатан, өргөн сонголттой үйлчилгээ одоогоор Мобикомоос өөр операторт байхгүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хэрэв та “Миний Моби” үйлчилгээг сонирхож эхэлсэн бол 2017 оны эхний улирлыг дуустал урамшуулалтай байгааг дуулгая. Та Мобикомын сүлжээ болон бүх операторын сүлжээнд хязгааргүй ярих, эсвэл мессэж бичих сонирхолтой бол дөрвөн төрлийн үйлчилгээний эрхээс сонгоно.

Хэрэв та ярих, мессэж бичихээс илүү харилцаа холбооны бүх асуудлаа цахим ертөнцөөр зохицуулдаг бол зөвхөн дата хэрэглээнд суурилсан багцыг сонгож болно.

Цахим ертөнцөд аялахад ДАТА нэг ёсны шатахуун болдог. Тиймээс “Миний Моби” үйлчилгээний дата хэрэглээний эрхтэй багц сонгосон хэрэглэгчдэдээ датаных нь хэмжээг хоёр дахин үржүүлэх урамшууллыг алдалгүй ашиглахыг зөвлөж байна. Хэрэв та 1GB дата сонговол тэр нь 2GB болно. Энэ мэтээр 5 нь 10, 10 нь 20 болон үржиж байна.

Хэрэглээний эрх	Сонголт	Үнэ	Урамшуулал
Дата хэрэглээний эрхтэй “МИНИЙ МОБИ” багц	1GB хязгааргүй дата	14'900₮	2GB дата. 2GB хүртэл хэрэглээнд хурдны хязгааргүй ба 2GB-аас дээших хэрэглээнд 128Kbps хурдаар ашиглана.
	5GB хязгааргүй дата	24'900₮	10GB дата. 10GB хүртэл хэрэглээнд хурдны хязгааргүй ба 10GB-аас дээших хэрэглээнд 128Kbps хурдаар ашиглана.
	10GB хязгааргүй дата	33'900₮	20GB дата. 20GB хүртэл хэрэглээнд хурдны хязгааргүй ба 20GB-аас дээших хэрэглээнд 128Kbps хурдаар ашиглана.

“Миний Моби” багцын урамшуулал зөвхөн үүгээр дуусахгүй. Та 60-аас дээш настай, эсвэл 18-23 насны хүн бол энэ багцын шинэ хэрэглэгч болоход бүр ч азтай байна гэсэн үг. Мобиком корпораци шинэ хэрэглэгч болсон 18-23 насны залуустаа жилийн турш сар бүр 1GB дата бэлэглэх бол 60-аас дээш насны ахмадууддаа мөн л бүтэн жил сар болгоны багцын хураамжаас нь 4900 төгрөг хөнгөлөхөөр болжээ. Гэхдээ энэ урамшуулал 2017 оны гуравдугаар сар хүртэл үргэлжилнэ гэдгийг битгий мартаарай.

Түүнээс гадна хэрэглэгч та өөрийн нэр дээрх нэг дугаарыг “Миний Моби” багц руу үнэгүй шилжүүлэх эрх эдэлнэ.

Алдаж боломгүй бас нэгэн боломж байна. Энэ багцын хэрэглэгчдэд зориулсан өөр нэгэн урамшуулал бол зээлээр утас авахдаа хөнгөлөлт эдлэх. Тухайн хэрэглэгч “Samsung” брэндийн ухаалаг утсыг үндсэн үнээс нь 5-26 хувь буюу 395.000 төгрөг хүртэл хөнгөлөлттэй, хүүгүй зээлээр авах юм. Жишээ нь, таны сарын хэрэглээ 30.000–50.000 төгрөг байдаг бол Samsung Galaxy S7 edge утсыг өөрийн үнээс нь 14 хувийн хөнгөлөлттэйгөөр буюу 245.000 төгрөгөөр хямд авах боломжтой. ■

	Хэрэглээний эрхийн сонголт	Үнэ	Урамшуулал
Ярианы эрх	Сүлжээндээ хязгааргүй ярих эрх	9'900₮	128Kbps хурдаар дата үнэгүй ашиглана.
	Бүх сүлжээнд хязгааргүй ярих эрх	29'900₮	
Мессэж эрх	Сүлжээндээ хязгааргүй мессэж бичих эрх	4'900₮	
	Бүх сүлжээнд хязгааргүй мессэж бичих эрх	9'900₮	

4G LTE
powered by  Huawei

ХУРДНЫ ХУВЬСАЛ



Соёл

Мобикомын бүтээсэн ертөнц

А.СЭВЖИД

Аливаа үйлчилгээний стандартыг хэрэглэгч биш, мэргэжилтнүүд маш сайн судалгаанд үндэслэж гаргадаг. Гэхдээ анхдагч шалтгаан нь, мэдээж, хэрэглэгчийн хязгааргүй хүсэл бөгөөд түүнийг гүйцэлдүүлэхийн тулд аж ахуйн нэгж, албан байгууллага бүр шинэ техник технологи, дэвшилтэт тоног төхөөрөмж, зөв харилцаа бүхий менежмент нэвтрүүлэн үйлчилгээгээ улам хялбар, боловсронгуй болгодог гэж хэлж болно.

“Монголд анх удаа” гэх реклам бүрт ашиглах дуртай холбоо үгийн үүсэл Мобикомоос үүдэлтэй гэвэл үнэнээс хол зөрөхгүй. Учир нь харилцаа холбооны салбарт нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж гар утсанд шаардагдах бүх зүйлийг зөвхөн нэг дороос авах таатай нөхцөлийг салбартаа анх удаа бүрдүүлж чадсан нь яалт ч үгүй Мобиком билээ. Ямар сайндаа л орон нутгийнхан нийслэлд ирэхдээ “Нарантуул” захаар оролгүй буцдаггүйтэй адил “Теди” төвөөр оролгүй явна гэж байдаггүй болсон тухай яриа гарах вэ. Энэ нь гар утасны хэрэглээ малчны хотонд хүртэл өдөр тутмын хэрэгцээ болсны баталгаа юм.

Холбоо харилцааны салбарт шинэ технологи нэвтрэх тусам хэрэглэгчдийн боловсрол дээшилж, үйлчилгээний чанар илүү өндөр түвшин шаардах болжээ. Сүүлийн үед нийслэлд тэнгэр баганадсан оффис, худалдааны төвүүд баригдаж, бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчдэд илүү тухай орчинд хүргэхийг чухалчилж байна. Тэдгээр сүрлэг үйлчилгээний барилгад Мобиком корпораци салбараа нээсэн тохиолдолд тухайн бизнес төвийн нэр хүнд өсдөг бичигдээгүй хууль гарсан байна. Мобикомын хувьд дурын нэг оффист салбараа нээчихдэггүй аж. Тухайн барилгад салбараа нээхийн тулд эхлээд хэрэглэгчийн ая

тух, аюулгүй байдлыг хангасан байх шаардлага тавьдаг. Жишээ нь, гадаа талбайдаа машины зогсоолтой, дулаахан, агааржуулалтын цогц шийдэлтэй, хэрэглэгчдийн аюулгүй байдлыг



дээд зэргээр хангасан байх нь зайлшгүй чухал. Энэ бол Мобиком хэрэглэгчийнхээ хүслээс урган гарсан үйлчилгээний стандарт шаардлагыг бусад байгууллагад тавьж чаддаг гэсэн үг юм. Магадгүй эдгээр зүйл өдгөө мэдээжийн мэт бодогдож болох ч уг стандартыг Мобиком анх тогтоосон байна.

Монголд үүрэн телефоны үйлчилгээ 1996 онд нэвтрэхэд бид Мобикомтой анх танилцсан. Түүнээс хойш өдгөө 20 жил өнгөрөхөд Мобиком харилцаа холбооны 64 салбар, 2200 гэрээт, 10 мянга гаруй хөдөлгөөнт борлуулагчаар дамжуулан үйлчилгээгээ хүргэж байна.

Тэд монголчууддаа төдийгүй гадаад дахь хэрэглэгчдэдээ ч анхаарал тавихаа мартдаггүй. Үүний илрэл нь манай улсад аялал жуулчлал, албан томилолтоор ирсэн болон Монголд амьдран суудаг гадаад иргэдэд үйлчлэх тусгай салбар нээсэн явдал юм. Гадаад хэрэглэгчдийнхээ ▶

► хэрэгцээ, сэтгэл ханамжийн баталгааг хангасан үйлчилгээ нэвтрүүлэхийн тулд төрөлх хэлээр нь ярьж, мэдээлэл өгч тайлбарлах үйлчилгээний ажилтнуудыг мэргэжлийн түвшинд бэлтгэж, зөвхөн гадаад харилцагчдад үйлчлэх “Олимп” салбараа нээсэн нь салбартаа түрүүлж алхдагийн бас нэг тод жишээ байлаа. Ингэснээр дотоодын зах зээл дээрх гадаад хэрэглэгчдэд илүү ойртож, тэдний хүсэл бодлыг сонсож чадах болсон нь үйлчилгээний чанараараа дэлхийн стандартад бас нэг алхам дөхсөн хэрэг юм.

Орчин үед монголчууд гар утсаараа зөвхөн харилцаа холбоогоо зохицуулахаас гадна банкны гүйлгээ, худалдаа арилжаагаа хүртэл хийж, үүнийг дагаад үйлчилгээ илүү хурдан, үр дүнтэй байхыг шаардах болжээ. Үүний нэг жишээ нь цахим үнэмлэхээ ашиглан ТҮЦ машинаас



төрийн үйлчилгээг хурдан шуурхай авдаг болсон явдал билээ. Харин үүнийг Мобикомынхон маш соргогоор ажиглаж цэнэглэгч карт, гар утасны дугаар авах үйлчилгээг дараалал хүлээлгүйгээр цахим үнэмлэх болон төлбөрийн картаа ашиглан зориулалтын автомат машинаас авах боломжтой болгосон байх жишээтэй. Энэ үйлчилгээ бас л Монголдоо анхдагч нь болсон гэдгийг дурдахгүй өнгөрч боломгүй. Мэдээж, энэ бол харилцаа

холбооны бүтээгдэхүүнийг иргэдэд хамгийн шуурхай хүргэж, үйлчилгээний хөгжлийн шатаа дахин нэгээр ахиулж чадсаны илрэл болжээ. Хэдхэн жилийн өмнө “Дугаар авахад үйлчилгээний ажилтан хэрэггүй” гэсэн бол уучлаарай, та андуурч гэж бодох байсан биз. Гэхдээ энэ бүхэн өнөөдөр ажил хэрэг болсныг харахад нэн таатай.

Мэдээж, олон мянган үйлчлүүлэгчтэй байгууллагад хамгийн том асуудал бол чадварлаг боловсон хүчин. Ажилтны буруу үйлдлээс болж байгууллага нэг үйлчлүүлэгчээ алдвал түүний цаана ахиад арвыг давхар алдана. Энэ талаар Мобиком корпорацийн Хэрэглэгчийн борлуулалтын газрын захирал Б.Баярмаа “Хэрэглэгчийн хүлээлтээс давсан үйлчилгээ үзүүлэхийн тулд манай ажилтнууд харилцагчдад эелдэг, дотно уур амьсгал хүргэх шаардлагатай. Тиймээс бид ажилчдадаа зориулан харилцааны олон төрлийн сургалтууд тогтмол явуулж, хөдөө орон нутгийн салбарынхандаа онлайнар хичээл заадаг. Бусад компани энэхүү сургалтын загвараа бидэнд өгөөч гэдэг хүсэлт тавих тохиолдол бий” гэж ярьсан. Өөрөөр хэлбэл, Мобикомын үйлчилгээний ажилтнууддаа тавьдаг стандарт шаардлагыг зөвхөн харилцаа холбооны салбар гэлтгүй бусад компани хүртэл бизнесийн үйл ажиллагаандаа ашигладаг болсон нь салбарын тэргүүлэгч компанийн хүлээсэн үүрэг гэлтэй.

Зөвхөн ярих, зурвас илгээх хэрэгцээнээс давсан гар утас өнөө цагт хүмүүсийн амьдралын салшгүй нэгэн орон зайг бүрдүүлж чадсан нь үйлдвэрлэгч компаниудыг шаргуу ажиллуулахад хүргэж байгаа. Монголчуудын гар утасны хэрэглээ эхэн үедээ Nokia, Seimens, Motorola-гаар хязгаарлагдаж байсан бол өдгөө Apple, Samsung брэндийнх болж чанаржин, өргөжсөн. Тэгвэл эдгээр брэнд гар утсыг албан ёсны эрхтэйгээр, тухайн улсын зах зээлд гарсан даруйд нь хэрэглэгчдэд танилцуулах буухиаг бас л Мобиком эхлүүлжээ. Мөн тун удахгүй LG болон Huawei брэндийн гар утаснуудыг борлуулж эхлэх гэж байна. Дэлхийн хаана шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрнэ, түүнийг дотоодын хэрэглэгчдэдээ шилэн хоргоноос харуулах биш гарт нь бодитоор бариулдаг болсноороо Мобиком бусад компаниудаа дагуулж чадсан билээ.

Дээр дурдсан бүхэн энгийн мэт боловч зөвхөн хэрэглэгч таны юу хүсэж буй болон юу хүсэх вэ гэсэн үндсэн шалтгааны үр дүнд буй болжээ. Тэгэхээр хэрэглэгч та өнөөдрийн “Мобиком”-ын үйлчилгээний өнгө төрхийг бий болгоход шууд болон шууд бусаар оролцсон гэсэн үг. Хэрвээ та хүсээгүй бол энэ үйлчилгээ байхгүй байх байсан. Иймээс ашгаас түрүүлж хэрэглэгчийнхээ хүслийг сонсож чадсан нь 20 жилийн түүхтэй Мобиком корпорацийн амжилтын нэг нууц аж. ■

Технологи

2020 онд гар утас ямар болох вэ?

М.БИЛГҮҮН

Японы үүрэн телефоны гол операторын нэг KDDI компанийн дэргэдэх “au” судалгааны төвөөс гар утас хэрэглэгчдийн дунд судалгаа явуулжээ. Судалгааны дүнд үндэслэн ойрын ирээдүйд гар утас хэрхэн өөрчлөгдөх талаар таамаглал дэвшүүлсэн байна.

Гар утас “амьтай” болно

Ойрын ирээдүйд гар утас хүний дотны “найз” болох бөгөөд гар утастайгаа ярьж, зөвлөгөө авах боломжтой болох гэнэ. Гар утсанд хүний тархины бичлэг хийх төхөөрөмж суурилагдах ба энэхүү төхөөрөмж хэрэглэгчийн зан чанар, сэтгэхүйн онцлогийг тодорхойлно. Улмаар зан чанарын хувьд тухайн хэрэглэгчтэй хамгийн нийцэх нэгэн хийсвэр дүр бүтээх бөгөөд тэр дүр нь хэрэглэгчийн хамгийн дотны “найз” нь болох гэнэ. Энэхүү төхөөрөмжийн тусламжтай хэрэглэгч өөрийнхөө дотор нуугдах өөр нэг дүрийг бүтээх юм. Хийсвэр дүрийн харагдах байдлыг хэрэглэгч загварчлан бүтээх боломжтой. Гар утастайгаа харилцах энэхүү систем нь шинэ зүйл биш бөгөөд Японы үүрэн харилцааны “Докомо” компанийн дээрхтэй төстэй “iconshell” хэмээх дээрхтэй төстэй бүтээгдэхүүн өнөө ч хэрэглэгдэж байна.

Өөрийн утсыг өөрөө бүтээнэ

Гар утас нь харилцааны хэрэгсэл төдийгүй загварын чиг хандлага болжээ. 2020 он гэхэд хүн бүр өөрийн сонирхолдоо нийцүүлэн утасныхаа өнгө үзэмж, хэлбэр дүрсийг өөрчлөх боломжтой болох гэнэ. Үүний тулд заавал гар утас үйлдвэрлэгчид хандах шаардлагагүй. Гудамжинд байрлах автомат машины тусламжтайгаар хүссэн хэлбэр, хэмжээтэй утсаа бүтээх боломжтой болох аж. Автомат машинд 3D хэвлэгч суурилагдсан байх бөгөөд хэрэглэгч гар утасны хэмжээ, дизайны талаарх мэдээллээ оруулснаар дахин давтагдашгүй гар утас бүтэх юм. Гэхдээ гар утасны дотоод эд ангийг 3D хэвлэгчээр бүтээх



боломжгүй тул зөвхөн гаднах гэрийг бүтээх аж.

Бичил дрон

Гэрэл зураг сонирхогчид төдийгүй жирийн хэрэглэгчдийн дунд хамгийн ихээр хүлээлт үүсгээд байгаа энэхүү төсөл 2020 онд хэрэгжиж эхэлнэ хэмээн таамаглаж байна. Гар утсанд бага оврын дрон суурилуулах бөгөөд энэхүү дроны тусламжтайгаар 100 метрийн радиуст зураг авах боломж нээгдэх юм. Дроныг гар утсаараа удирдана. Гэхдээ уг төсөл дээр ажиллаж буй Ками Мүкэ хэлэхдээ “Олон хүн цугласан газар дрон мөргөлдөх, хүний дээрээс унах зэрэг асуудал үүсэх магадлалтай тул аюулгүйн журам батлах шаардлагатай болов уу” гэв. Ямар боловч дрон бидний амьдралын салшгүй хэсэг болох цаг ойртсоор байна.

Нэг удаагийн гар утас

“Нэг удаагийн гар утас” төсөл дээр ажиллаж буй Комурагийн хэлж байгаагаар энэхүү утас нь тухайн улсад богино хугацаагаар зорчих гадаадын иргэдэд хамгийн тохиромжтой гэнэ. Уг утас пластик материалаар хийгдэх бөгөөд хэрэглэгч гар дээрээ наан хэрэглэх боломжтой. “Мессеж бичих, утсаар ярих” зэрэг энгийн чадамжуудтай байхаар төлөвлөж байгаа аж.

Хүн бүрт хүртээмжтэй интернэт

Гар утас компьютерийг орлох болсон. Гар утас олон нийтийн сүлжээнд холбогдох, цахилгаан шуудан илгээх, мэдээлэл хайх зэрэг олон үйлдэл гүйцэтгэх чадамжтай болсоор байна. Гэхдээ дээрх үйлдлүүдийг зөвхөн интернэтээр гүйцэтгэх боломжтой юм. 2020 онд хаа ч явсан гар утсаараа интернэтэд холбогдох боломжтой болох аж. Нарны эрчим хүчээр цэнэглэгддэг дэлгэцийн хүчээр хаа байгаа газраасаа интернэтэд холбогдох гэнэ. ▶

► Гар утас хэтэвчийг орлоно

Ухаалаг утас бидний хэрэглэж заншсан олон зүйлсийг хэрэглээнээс шахан гаргасан. Тэгвэл удахгүй хэрэглээнээс гарах зүйлсийн жагсаалтад хэтэвч орох нь ээ. Учир нь ойрын ирээдүйд ямар нэгэн худалдан авалтыг гар утсаар гүйцэтгэх гэнэ. Өнөөдөр ч хүмүүс Venmo, Apple Pay зэрэг үйлчилгээг ашиглагдаж байгаа. Харин 2020 он гэхэд гар утас худалдааны гол хэрэгсэл болно хэмээн таамаглаж байгаа юм.

Бодит ертөнцийг өөрчлөх нь

Бодит байдлыг өөрийн хүссэнээр өөрчлөх боломжтой. Гар утсаараа авсан зураг, бичлэг, GPS мэдээ зэрэг бодит байдлыг тусгасан мэдээлэлд AR

/augmented reality/ програмаар виртуаль эффект оруулах боломжтой болох юм. Энэхүү программ нь ойрын ирээдүйд хамгийн эрэлттэй байх бөгөөд хэрэглэгчдэд бодит ертөнцийг өөрийн хүссэнээр өөрчлөх боломж олгох юм.

3D-гийн дараа?

Хүний нүд бол хамгийн төгс оптик багаж юм. Харин ойрын ирээдүйд гар утас төгс төгөлдөрт дөхөж очих нь ээ. Энэ бол 3D болоод Холографийн хосолсон систем юм. Яг л “оддын дайн” кинонд гардаг шиг харилцаж буй хүний дүрсийг бодитоор харуулах, материйг олон талаас нь харах боломж бүрдэх аж. Энэхүү системийг дэлхийн гар утасны зөвлөлөөс нэвтрүүлэхийг зөвшөөрсөн байна. ■

Сонирхолтой аппликэйшнүүд

Ухаалаг утас таны төсөөлж байгаагаас ч олон зүйл бүтээж чадна. Доорх аппликэйшнүүдийг суулгаснаар амьдрал илүү хялбар бас сонирхолтой болно гэдэгт итгэлтэй байна. Дашрамд дурдахад эдгээр аппликэйшнийг үнэгүй татах боломжтой юм.

Дасгалжуулагч

321runfree Энэхүү программыг спортлог хүмүүст зориулан бүтээжээ. Уг программыг утсандаа суулгаснаар зааланд гүйх явцдаа биеийнхээ байдлыг хянах боломжтой. Мөн биедээ тохирсон дасгал хийхэд туслах болно.

Тэгш хэм


ИHandy Level Та барилгачин бол, эсвэл танд тэгш хэм хэрэглэх шаардлага үе үе гардаг бол энэ программыг ашиглаарай. Утсаа тухайн гадарга дээр тавьснаар хазаалттай, суулттай эсэхийг мэдэх боломжтой.

Ой

Сүүлийн жилүүдэд гар утсанд донтох эмгэг ихсэж байгаа нь эмч нарын санааг зовоох болов. Хэрэв та ухаалаг утсыг ухаалгаар хэрэглэж сурахыг хүсвэл Forest программ хэрэглээрэй. Та утсаа хэрэглэх дээд хугацааг утсандаа суулгах бөгөөд тохиролцсон хугацаанд тань утсаа унтраахыг шаардах дохио ирнэ. Ингээд утсаа унтраах үед бяцхан мод ургаж эхэлнэ. Та олон мод ургуулах тусам ухаалаг утас тань таныг урамшуулах буюу оноогоор шагнах юм.

НАСА

Дэлхийн шинжлэх ухааны тэргүүлэгч байгууллага бол АНУ-ын агаар мандал, сансар судлалын үндэсний агентлаг



гэдэгтэй хүн бүр санал нийлэх биз. Тэгвэл та NASA APP программыг утсандаа суулгаснаар НАСА-тай хөл нийлүүлэн алхах боломжтой. Сансар судлалын сүүлийн үеийн мэдээг цаг алдалгүй авч, зөвхөн сансрын нисгэгчийн харж болох гайхамшигт үзэмжийг утсан дээрээ харах боломжтой.

Коктейл хийж сурмаар байвал

Хэрэв та коктейл үдэшлэг хийх гэж байвал эсвэл зүгээр л коктейл уух

дуртай бол энэхүү программыг татаж аваарай. Cocktail Flow - Drink recipes программыг ашигласнаар коктейл найруулах шилдэг арга, жоруудыг сурах боломжтой. Зөвхөн коктейл төдийгүй хүйтэн ундаа бэлтгэж сурахыг хүсэж байвал энэхүү программыг ашиглаарай.

Зөгнөлт кино бүтээх боломж

Стивен Спилберг жирийн л сонирхогчоос найруулагчийн гараагаа эхэлсэн. Та ч гэсэн түүний дараах алдарт кино найруулагч ч юм билүү. FxGuru: Movie FX Director программ нь кино сонирхогчдод зориулсан программ бөгөөд үүгээр өөрөө кино бүтээх боломжтой. Энэхүү программыг ашиглан уран сэтгэмжээ хөгжүүлэхийг санал болгож байна.

Бухын нүд

Заримдаа хэн нэгнээс зөвлөгөө авмаар байвч зөв зам зааж чиглүүлэх хүнтэй тэр бүр таардаггүй нь харамсалтай. Харин My Magic 8 Ball программ ашигласнаар ухаалаг утас тань таныг асуултанд хариу өгөх болно. Ухаалаг утсаа сэгсрээд асуулт тавь. Утас тань юу хийхийг заана. Төгс хариулт өгөхгүй байж болох ч эргэлзээг тань тайлж чадна гэдэгт итгэлтэй байна. ■

МИНИЙ МОБИ ХЯЗГААРГҮЙ ШИНЭ ХЭРЭГЛЭГЧИЙН УРАМШУУЛАЛ



ШИНЭ ХЭРЭГЛЭГЧ



эхний дугаарын
БАРЬЦАА ТӨЛБӨР **0₮**



18-23 НАСНЫ ЗАЛУУСТАА
12 сарын турш



1GB дата багцыг сар бүр
БЭЛЭГЛЭНЭ



**60 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ
НАСНЫ АХМАДУУДАА**
12 сарын турш



4'900₮ сар бүр багцын хураамж
ХӨНГӨЛӨЛТТЭЙ

МИНИЙ МОБИ ХЯЗГААРГҮЙ ОДООГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН УРАМШУУЛАЛ

ДАТА ХЭРЭГЛЭЭ 2 ДАХИН ҮРЖИГДЭНЭ

Дата хэрэглээний эрхтэй багц

1GB 2GB ҮНЭ **14,900₮**

Хязгааргүй дата

2GB хүртэл хурдны хязгааргүй,
2GB-аас дээш 128Kbps хүртэлх хурдаар ашиглана

5GB 10GB ҮНЭ **24,900₮**

Хязгааргүй дата

10GB хүртэл хурдны хязгааргүй,
10GB-аас дээш 128Kbps хүртэлх хурдаар ашиглана

10GB 20GB ҮНЭ **33,900₮**

Хязгааргүй дата

20GB хүртэл хурдны хязгааргүй,
20GB-аас дээш 128Kbps хүртэлх хурдаар ашиглана

ДАТА ЗАДГАЙ ХЭРЭГЛЭЭ ТӨЛБӨРГҮЙ БОЛЛОО

Яриа, мессэж хэрэглээний эрхтэй багц

ЯРИА

МЕССЭЖ

Сүлжээндээ хязгааргүй*

9,900₮

4,900₮

Бүх сүлжээнд хязгааргүй*

29,900₮

9,900₮

ҮНДСЭН НӨХЦӨЛ

128 Kbps ХҮРТЭЛХ
хурдаар дата үнэгүй
АШИГЛАХ БОЛОМЖТОЙ

☎ **2222, 1800-2222** бусад сүлжээнээс

Урамшууллын хугацаа
2017.03.31-нийг дуустал

📱 🌐 MobiComOfficial

🌐 www.mobicom.mn



*Зүй зохистой хэрэглээнд ашиглана